ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

# АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ТАЙЛАН 2018

Улаанбаатар хот
2019 он

# ӨМНӨХ ҮГ



Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд Монгол Улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүдийн талаарх тоон мэдээллийг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан нийтлэг тодорхойлолт, аргачлалын дагуу явуулж буй “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнд үндэслэн албан ёсны статистик болгон тархааж байна.

Ажиллах хүчний судалгааг 2006 оноос эхлэн тогтмол явуулж, үр дүнг улсын хэмжээнд болон бүс нутаг, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд улирал, жилийн давтамжтайгаар тархаадаг. Энэхүү түүвэр судалгаа нь хөдөлмөрийн зах зээлийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тодорхойлж, дүн шинжилгээ хийхэд ашиглагдах тоон мэдээллийн багцыг бий болгодог зэрэг ач холбогдолтой юм.

Иймд энэхүү судалгааны тоо мэдээлэл, үр дүнгийн тайлан нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт төдийгүй эрдэмтэн, судлаач болон сонирхсон хэн бүхэнд хамгийн сүүлийн үеийн бодит мэдээлэл, гарын авлага болно гэдэгт итгэлтэй байна.

Эрхэм хэрэглэгч Таны Монгол Улсын Хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулж боловсронгуй болгох, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээ мэдээлэл, тайлангийн үзүүлэлтүүдийн ашиглалтыг үр ашигтай болгоход чиглэгдсэн саналыг бид хүлээн авч, хамтран ажиллахад бэлэн байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА



А.АРИУНЗАЯА

# ГАРЧИГ


ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ ........ 6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ ........ 7
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ ........ 9

БҮЛЭГ I. УДИРТГАЛ
1.1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ ........ 13
1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО ........ 13
1.3. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ ........ 13
1.4. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ........ 14
1.4.1 Судалгааны асуулгын хуудас ........ 14
1.4.2 Мэдээлэл цуглуулалт ........ 15
1.4.3 Мэдээлэл боловсруулалт ........ 16
1.4.4 Нийтийн хүртээл болгох ........ 16

БҮЛЭГ II. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АРГАЧЛАЛ
2.1 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ ........ 21
2.2 АРГАЧЛАЛ ........ 25

БҮЛЭГ III. СУДАЛГААНЫ ТОВЧ ДҮН
3.1 ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ ........ 31
3.2 ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ ........ 31
3.3 АЖИЛЛАГЧИД ........ 32
3.4 УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ ........ 33
3.5 АЖИЛГҮЙ ИРГЭД ........ 33

БҮЛЭГ IV. ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
4.1. ӨРХ, ХҮН АМ ЗҮЙ ........ 37
4.2. ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ ........ 38
4.3. БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ ........ 39

БҮЛЭГ V. ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ
5.1 ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ ........ 43
5.2 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН ........ 44
5.2.1 Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлгээр ........ 44
5.2.2 Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшнээр ........ 45
5.2.3 Ажиллах хүчний оролцооны түвшин, гэрлэлтийн байдлаар ........ 46
5.3 ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ ........ 47

БҮЛЭГ VI. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
6.1 ТУХАЙН ҮЕИЙН АЖИЛЛАГЧИД ........ 49
6.2 АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР ........ 54
6.3 АЖИЛЛАГЧИД, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР ........ 56
6.4 АЖИЛЛАГЧИД, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР ........ 58
6.5 АЖИЛЛАГЧИД, БАЙГУУЛЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭРЭЭР ........ 59
6.6 ДАВХАР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ........ 60

БҮЛЭГ VII. АЖИЛГҮЙДЭЛ
7.1. АЖИЛГҮЙ ИРГЭД ........ 63
7.2 АЖИЛГҮЙДЛИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА ........ 64
7.3. АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН ........ 64
7.4. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН ........ 65
7.5 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН ........ 68

БҮЛЭГ VIII. ЗАЛУУЧУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ
8.1 ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ ........ 73
8.2 ЗАЛУУЧУУДЫН АЖИЛГҮЙДЭЛ ........ 79

БҮЛЭГ IX. АЛБАН БУС САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
9.1 АЛБАН БУС САЛБАРТ АЖИЛЛАГЧИД ........ 83
9.2 АЛБАН БУС САЛБАРТ АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР ........ 84
9.3 АЛБАН БУС САЛБАРТ АЖИЛЛАГЧИД, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР ........ 85

БҮЛЭГ X. АЖЛЫН ЦАГ БОЛОН ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
10.1 АЖЛЫН ЦАГ ........ 89
10.2 ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ........ 90

БҮЛЭГ XI. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ
11.1 ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДАЛ ........ 97
11.2 АЖИЛЛАГЧИД ........ 97
11.3. АЖИЛГҮЙ ИРГЭД ........ 98

БҮЛЭГ XII. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ СҮҮЛИЙН 8 ЖИЛИЙН ҮНДСЭН ҮР ДҮНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ
12.1. ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДАЛ ........ 103
12.1.1 АХОТ-ний динамик харьцуулалт, хүйс, насны бүлэг, бүс нутгаар ........ 103
12.1.2 АХОТ, боловсролын түвшин болон гэрлэлтийн байдлаар ........ 106

12.2 АЖИЛЛАГЧИД ........ 107
12.3 АЖИЛГҮЙ ИРГЭД ........ 108

БҮЛЭГ XIII. СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ
13.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ ........ 115
13.2 ТҮҮВЭРЛЭЛТ ........ 115
13.3 ТҮҮВРИЙН АЛДАА ........ 118

ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД ........ 125

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 4.1. 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, байршил, хүйсээр, дүнд эзлэх хувиар ..... 39
Хүснэгт 5.1. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн ..... 43
байдал, байршил, хүйсээр ..... 43
Хүснэгт 5.2. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам, насны бүлгээр, шалтгаанаар, хувиар ..... 48
Хүснэгт 6.1. Ажиллагчид, байршил, бүс, хүйсээр ..... 51
Хүснэгт 6.2. 18, түүнээс дээш насны ажиллагчдын гэрлэлтийн байдал, хүйс, байршлаар ..... 52
Хүснэгт 6.3. Ажиллагчид, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэр, байршлаар ..... 59
Хүснэгт 6.4. Давхар хөдөлмөр эрхэлсэн хүн ам, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр.. 60
Хүснэгт 7.1. 15, түүнээс дээш насны хүн амд ногдох ажилгүй иргэд, бүсээр ..... 63
Хүснэгт 7.2. Ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, хүйсээр, дүнд эзлэх хувиар ..... 65
Хүснэгт 8.1. Залуу ажиллагчид, байршил, бүс, хүйсээр ..... 73
Хүснэгт 8.2. Залуу ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр ..... 75
Хүснэгт 8.3. 15-24 насны ажилгүй иргэд, нийт ажилгүй иргэдэд эзлэх хувь, ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр ..... 79
Хүснэгт 8.4. 15-24 насны ажилгүй иргэд, нийт ажилгүй иргэдэд эзлэх хувь, ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, байршлаар ..... 79
Хүснэгт 9.1. Албан бус салбарт ажиллагчид, хүйс, байршил, бүсээр ..... 83
Хүснэгт 9.2. Албан бус салбарт ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ..... 84
Хүснэгт 9.3. Албан бус салбар дахь ажиллагчид, ажил мэргэжлийн ангиллаар, хүйсээр ..... 86
Хүснэгт 10.1. Долоо хоногт зарцуулдаг байнгын ажлын цаг нь богино болон урт байдаг ажиллагчид, хувиар ..... 90
Хүснэгт 10.2. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар, хувиар ..... 93
Хүснэгт 12.1. 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх ..... 103
Хүснэгт 12.2. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, гэрлэлтийн байдлаар ..... 106
Хүснэгт 12.3. Залуучуудын болон нийт ажилгүйдлийн түвшний харьцаа ..... 108

# ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 4.1. Ажил эрхэлдэг иргэнтэй өрх, өрхийн ам бүл, өрхөд ажил эрхэлж байгаа хүнээр ... 37
Зураг 4.2. Ажилгүй иргэнтэй өрх, өрхийн ам бүл, өрхөд ажилгүй байгаа хүнээр ... 38
Зураг 4.3. 18, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, хувиар... 38
Зураг 4.4. 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, ... 40
байршлаар... 40
Зураг 5.1. Ажиллах хүчний оролцооны түвшин, байршил, хүйсээр ... 44
Зураг 5.2. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр... 44
Зураг 5.3. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, байршлаар... 45
Зураг 5.4. Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшнээр ... 46
Зураг 5.5. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, гэрлэлтийн байдлаар ... 46
Зураг 5.6. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, байршлаар... 47
Зураг 5.7. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар, хувиар, хүйсээр ... 47
Зураг 5.8. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам, зарим шалтгаанаар, хүйсээр, хувиар ... 48
Зураг 6.1. Ажиллагчид, байршил, хүйсээр ... 51
Зураг 6.2. Ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар... 53
Зураг 6.3. Ажиллагчдын боловсролын түвшин, хүйсээр ... 53
Зураг 6.4. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хүйсээр . 54
Зураг 6.5. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, дүнд эзлэх хувиар ... 55
Зураг 6.6. ХАА-н бус салбарт цалин хөлстэй ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, салбараар... 56
Зураг 6.7. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар ... 57
Зураг 6.8. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр... 57
Зураг 6.9. Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар... 58
Зураг 6.10. Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүйсээр ... 58
Зураг 6.11. Ажиллагчид, байгууллагын хариуцлагын хэлбэр, бүсээр, дүнд... 59
эзлэх хувиар ... 59
Зураг 7.1. Ажилгүй иргэдийн насны бүтэц, хүйсээр, хувиар ... 64
Зураг 7.2. Ажилгүй иргэд, ажил хийх боломжтой байсан хугацаагаар, хувиар ... 64
Зураг 7.3. Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр ... 66
Зураг 7.4. Ажилгүйдлийн түвшин, аймаг, нийслэлээр ... 67
Зураг 7.5. Ажилгүйдлийн түвшин, боловсролын түвшин, хүйсээр ... 67
Зураг 7.6. Ажилгүйдлийн түвшин, гэрлэлтийн байдлаар ... 68
Зураг 7.7. Ажилгүй иргэд, хөдөлмөр эрхлээгүй шалтгаанаар, хувиар... 68
Зураг 7.8. Ажил хайгаад олдохгүй байгаа ажилгүй иргэд, эзэмшсэн ажил мэргэжлээр, хувиар ... 69
Зураг 7.9. Мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа ажилгүй иргэд, эзэмшсэн ажил мэргэжлээр, хувиар ... 70
Зураг 8.1. Залуу ажиллагчид, аймаг, хүйсээр ... 74
Зураг 8.2. Залуу ажиллагчид, аймгаар, нийт ажиллагчдад эзлэх хувиар... 75
Зураг 8.3. Залуу ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр... 76
Зураг 8.4. Залуу ажиллагчдын, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар... 76
Зураг 8.5. Залуу ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар ... 77
Зураг 8.6. Залуу ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар ... 78
Зураг 8.7. Залуу ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар, хүйсээр 78
Зураг 8.8. 15-24 насны ажилгүй иргэд, хөдөлмөр эрхлээгүй шалтгаанаар, хувиар ... 80
Зураг 9.1. Албан бус салбарт ажиллагчид, байршил, бүсээр, хувиар ... 84
Зураг 9.2. Албан бус салбарт ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хувиар ... 85
Зураг 9.3. Албан бус салбарт ажиллагчдын сэтгэл ханамжийн байдал ... 86

Зураг 10.1. Ажиллагчдын бүх ажилдаа зарцуулдаг долоо хоногийн байнгын ажлын цагийн дундаж, хүйсээр ..... 89
Зураг 10.2. Ажиллагчид, бүх ажилдаа зарцуулдаг долоо хоногийн байнгын ажлын цагаар, хувиар ..... 89
Зураг 10.3. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, насны бүлгээр, хүнээр ..... 91
Зураг 10.4. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн тархалт, боловсролын түвшнээр, дүнд эзлэх хувиар ..... 92
Зураг 10.5. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн ..... 92
тархалт, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, дүнд эзлэх хувиар ..... 92
Зураг 11.1. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр ..... 97
Зураг 11.2. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, улирлаар ..... 97
Зураг 11.3. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин, байршил, улирлаар ..... 98
Зураг 11.4. Ажилгүйдлийн түвшин, хүйс, улирлаар, хувиар ..... 99
Зураг 11.5. Ажилгүй иргэд, шалтгаанаар, улирлаар, хувиар ..... 99
Зураг 12.1. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр ..... 104
Зураг 12.2. Ажиллах хүчний оролцооны түвшин, байршлаар ..... 104
Зураг 12.3. 15-24 насны залуучуудын ажиллах хүчний оролцооны түвшин ..... 105
Зураг 12.4. Ахмад настны (55-аас дээш) ажиллах хүчний оролцооны түвшин ..... 105
Зураг 12.5. Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшнээр ..... 106
Зураг 12.6. Ажиллагчид, байршлаар, дүнд эзлэх хувиар ..... 107
Зураг 12.7. Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, дүнд эзлэх хувиар ..... 107
Зураг 12.8. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар, хувиар ..... 108
Зураг 12.9. Үндэсний болон залуучуудын ажилгүйдлийн түвшний харьцаа, хувиар ..... 109
Зураг 12.10. Ажилгүйдлийн түвшин, хүйсээр ..... 109
Зураг 12.11. Ажилгүйдлийн түвшин, байршлаар ..... 110
Зураг 12.12. Ажилгүй иргэд, ажил хийх боломжтой байсан хугацаагаар, хувиар ..... 111
Зураг 12.13. Ажилгүй 15-24 насны залуу иргэдийн хувь, ажил хийх боломжтой байсан хугацаагаар ..... 111

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ - Аж ахуй нэгж байгууллага

АХОТ - Ажиллах хүчний оролцооны түвшин

АХС - Ажиллах хүчний судалгаа

ББН - Бүх гишүүд нь бүрэн хариуцлагтай нөхөрлөл

ЗБН - Зарим гишүүд нь бүрэн хариуцлагтай нөхөрлөл

ЗДТГ - Засаг даргын тамгийн газар

ОНӨҮГ - Олон нийтийн өмчит үйлдвэрийн газар

ОУХБ - Олон улсын хөдөлмөрийн байгууллага

ТАШН - Түүврийн анхан шатны нэгж

ТБ - Төрийн байгууллага

ТББ - Төрийн бус байгууллага

ТӨҮГ - Төрийн өмчит үйлдвэрийн газар

ҮСХ - Үндэсний статистикийн хороо

ХАА - Хөдөө аж ахуй

ХК - Хувьцаат компани

ХХК - Хязгаарлагдмал хариуцлагтай компани

ХХЭ - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

# БҮЛЭГ I

# УДИРТГАЛ

## Ажиллах хүчний судалгааны түүхэн замнал



## 1.1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Монгол Улсад Ажиллах хүчний түүвэр судалгааг 2002-2003 онд хөдөлмөрийн статистикийг боловсронгуй болгох зорилгоор олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон билээ. Уг судалгааны үр дүнд үндэслэн ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, үр дүнг дүгнэхэд шаардлагатай статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, мэдээллийн давтамжийг тогтмолжуулах цаашлаад хөдөлмөрийн статистикийн системийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдсан. Энэхүү шаардлагын үүднээс олон улсын нийтлэг аргачлалын дагуу АХС-г улирлаар тогтмол явуулж байх нь зүйтэй гэж үзэн 2004 оны 4-р сарын 23-нд Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ё-д “Хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулж байх”-аар заасан. Иймд 2006 оноос эхлэн АХС-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн статистикийн бюллетень, танилцуулгад улирлаар, эмхэтгэлд жилээр оруулахаас гадна судалгааны тусгайлсан тайланг жил бүр тархааж байна.

## 1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Судалгааны үндсэн зорилго нь хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулж, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг бүрэн хамруулсан дүн шинжилгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, хөдөлмөрийн зах зээлийг зөв төлөвшүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг бий болгох, бүх шатны хэрэглэгчдийг мэдээллээр хангахад оршино. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн зах зээлийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тодорхойлж, дүн шинжилгээ хийхэд ашиглагдах тоон мэдээллийн багцыг бий болгоход оршино.

## 1.3. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

АХС-аар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодит тоон мэдээллийг улсын хэмжээнд болон бүс нутаг, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд тооцож тодорхойлно. Иймд судалгааг байршлын хувьд Монгол Улсыг бүхэлд нь хамруулан өргөн цар хүрээнд явуулж, 5 бүс нутгийн /Төв, Баруун, Зүүн, Хангай, Улаанбаатар/ нийт 12816 өрхийг хамруулдаг. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг бодитой тооцоход

хангалттай төлөөлөл болно. Нийт өрхийн дөрөвний нэгийг тухайн улирлын судалгаанд хамруулж, судалгааны мэдээллийг сар бүр цуглуулан, үр дүнг улирлаар нэгтгэж, боловсруулалт хийсэн.

Өрхөд суурилан явагдаж байгаа тул цэргийн хуаран, дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, сүм хийд болон нийтийн байранд түр амьдрагчид, байнгын орон гэргүй хүн амыг хамруулаагүй болно. Мөн тухайн өрхөд 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа /хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа/ иргэдийг хамруулдаггүй.

## 1.4. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 1.4.1 Судалгааны асуулгын хуудас

Судалгааны асуулга нь 8 бүлэг 142 асуултаас бүрдэж байна. Судалгааны асуулгад дараах мэдээллийг багтаасан болно. Үүнд:

1. Өрхийн гишүүдийн байдал (өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох, хүйс, төрсөн он, сар, өдөр, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, гэрлэлтийн байдал, шилжих хөдөлгөөнд оролцсон эсэх);
2. Боловсрол ба сургалт (сургуульд суралцсан, суралцаж байгаа эсэх, сургуулиас завсардсан шалтгаан, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг, мэргэжил олгох болон ур чадвар олгох сургалтанд хамрагдсан эсэх, эзэмшсэн мэргэжил);
3. Сүүлийн 7 хоног буюу тухайн үеийн идэвх (эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа, түүнд зарцуулсан цаг, эдийн засгийн идэвхтэй, идэвхгүй байдал, үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажил мэргэжлийн ангилал, үндсэн ажлынхаа цалин хөлсийг ямар хугацааны давтамжтай авдаг, авч буй цалин, хөлс, орлого);
4. Нэмэлт ажил хийх боломж (нэмэлт ажил хийх боломжтой эсэх, нэмэлт ажил хийх боломжгүй байсан шалтгаан, нэмэлт ажил хайсан хэлбэр);
5. Ажилгүй иргэн (ажил хийхэд бэлэн байсан эсэх, хэрэв ажил хийхэд бэлэн биш байсан бол эдийн засгийн идэвхгүй байсан шалтгаан, ажил хайсан хугацаа, ямар төрлийн/ажил мэргэжлийн ажил хийх хүсэлтэй байгаа, авахыг хүсч буй цалингийн хэмжээ (өдрийн, сарын), хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй эсэх, сүүлийн 30 хоногт ажил хайсан эсэх, ажил хайсан хэлбэр, ажил хайгаагүй шалтгаан, ажилгүй байсан хугацаа);
6. Эдийн засгийн байнгын идэвх (сүүлийн 12 сарын буюу эдийн засгийн байнгын идэвх, сүүлийн 12 сарын хугацааны үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлт,

түүнээс авсан дундаж цалин хөлс, орлого, хөдөлмөр эрхлэлтийн статус, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, ажилгүй байсан хугацаа, ажил хайсан хэлбэр) ;

7. Өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт (өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн байдал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, хамгийн сүүлийн ажлыг гүйцэтгэсэн хугацаа, хамгийн сүүлийн ажлаа хийхээ больсон шалтгаан, ажилгүй байх хугацаан дахь амьжиргааны эх үүсвэр);
8. Цалин хөлсгүй ажил, үйлчилгээ (өрхийн гишүүд цалин хөлсгүй ажил, үйлчилгээнд оролцсон эсэх, түүнд зарцуулсан цаг);

Судалгааны анхдагч мэдээллийн бааз нь дээрх мэдээллүүдийг агуулсан байдаг ба хэрэглэгч та “www.1212.mn Үндэсний Статистикийн Хороо /ҮСХ/-ны мэдээллийн сан”-гийн тооллого, судалгаа каталогоос судалгаа явагдсан бүх оны анхдаёч мэдээллийн баазыг үнэ төлбөргүйгээр татан авч, хэрэглэх боломжтой юм. Та http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/LFS/dataset холбоосоор дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

### 1.4.2 Мэдээлэл цуглуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн ажиллах хүчний судалгаа хариуцсан багийн ажилтнууд хийж гүйцэтгэдэг ба судлаач нь тухайн сард сонгогдсон өрхийн 15, түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж, ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулдаг.

Судалгааны мэдээллийг судлаач таблетаар цуглуулан, зааврын дагуу шалгаж, кодлон интернет орчинд ҮСХ-ны төв серверт байршуулдаг. Судлаачийн төв серверт байршуулсан мэдээллийг тухайн аймаг, нийслэлийн судалгааны багийн ахлагч серверт хандан шалгаж, ахлагчийн таблетаас эцэслэн дамжуулах замаар ҮСХ-нд мэдээлэл нэгтгэгддэг.

Судлаач сонгогдсон өрхөө судалгаанд бүрэн хамруулахын тулд судалгаа авах үеэр өрхийн гишүүд эзгүй байх тохиолдолд тухайн өрхөд эргэж 2-3 удаа очиж, судалгааны хамралтыг нэмэгдүүлдэг. Судалгаанд өрхийг бүрэн хамруулах, мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор судалгааны багийн ахлагч, аймаг, нийслэлийн статистикийн газар хэлтсээс хяналт тавьж, гарсан ололт, дутагдлыг тухай бүр нь танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

### 1.4.3 Мэдээлэл боловсруулалт

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын Ажиллах хүчний судалгааны алба уг судалгааг хариуцан ажилладаг бөгөөд, судалгааны асуулга боловсруулах болон мэдээллийн орох программыг бэлтгэх, мэдээллийн бүрдэлтийг нэгтгэх, шалгах, тодруулга хийх, боловсруулах, нэгдсэн үр дүнг тооцох, тайлагнах гэх мэт судалгааны бүхий л үе шатны ажлуудыг хийж гүйцэтгэдэг.

АХС–ны мэдээллийг цуглуулах, шалгахдаа CSPro багц программыг, мэдээллийн үр дүнг нэгтгэж боловсруулахдаа SPSS программыг ашигладаг. Судалгааны мэдээлэл цуглуулалтад таблет ашигладаг тул оролтын программд түлхүү анхаардаг.

### 1.4.4 Нийтийн хүртээл болгох

Ажиллах хүчний судалгааг тогтмол явуулж, мэдээллийг сар бүр бүх аймаг, дүүргийн сонгогдсон нэгжийн өрхүүдээс цуглуулж, улирлын үр дүнг статистикийн бюллетень, танилцуулгад /1 дүгээр улирлынх – 4 сарын, 2 дугаар улирлынх – 7 сарын, 3 дугаар улирлынх - 10 сарын, 4 дүгээр улирлынх дараа жилийн 1 сарын/ тусган, жилийн нэгдсэн үр дүнг статистикийн жилийн эмхэтгэлд тусган хэрэглэгчдэд хүргэж байна.

Хэрэглэгчдэд цахим хэлбэр буюу статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn сайтаар дамжуулан мэдээллийг үнэ, төлбөргүйгээр нийтийн хүртээл болгодог. Үүнд:

1. Хөдөлмөрийн статистикийн 1992 оноос хойших хугацааны 16 үзүүлэлтийг улирал, жилээр, үндэсний болон бүс нутаг, аймаг, дүүргийн хэмжээнд хүн ам зүйн холбогдох бусад үзүүлэлтээр мэдээллийг монгол, англи хэлээр оруулж, хүснэгт, график, газар зүйн байршлаар мэдээллийг харж, татаж авч болохуйцаар;
2. Монгол Улсын Нийгэм, эдийн засгийн байдлын сар бүрийн танилцуулгыг монгол, англи хэлээр;
3. Судалгааны улирлын товч танилцуулга болон тухай бүр хийсэн сэдэвчилсэн судалгааны тайлангуудыг уг сайтын судалгаа хэсэгт;
4. Судалгааны хувь хүний нууцлалыг бүрэн хангасан анхдагч мэдээллийн бааз болон баазын үзүүлэлтийн тайлбар толь, мэдээлэл цуглуулсан асуулга, жилийн үр дүнгийн тайлан болон бусад судалгааны тайлбар танилцуулгыг судалгаа явагдсан бүхий л хугацаагаар, монгол, англи хэлээр үнэ, төлбөргүйгээр татаж авахаар www.1212.mn сайтад байршуулаад байна.




Мөн судалгааны жилийн үр дүнгээр тусгайлсан тайлан бичиж, хэвлүүлэн тархаадаг бөгөөд IOS болон Android үйлдлийн системтэй гар утсанд зориулагдсан 1212.mn аппликейшнаар, нийслэл, аймгуудын ЗДТГ-т байрлах Статистикийн мэдээллийн электрон самбараар дээрх 4 төрлийн мэдээллүүдийг /мэдээллийн бааз, асуулгаас бусад/ болон ҮСХ-ноос гарч буй бүхий л хэвлэмэл бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүйгээр тархааж байна.

*Статистикийн мэдээллийн электрон самбар*




*1212.mn*



18

# БҮЛЭГ II

# ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ АРГАЧЛАЛ

20

## 2.1 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Судалгааг 2009 оны 6 дугаар сард батлагдсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”, Нэгдсэн Үндэстний Байгууллага болон ОУХБ-аас санал болгосон олон улсын нийтлэг стандарт бүхий ойлголт, тодорхойлолтын дагуу явуулсан. Ингэснээр энэ судалгааны үр дүнг ҮСХ-ноос явуулж байгаа бусад судалгаа, олон улсын зарим судалгааны үр дүнтэй зэрэгцүүлэн дүн шинжилгээ хийх боломжийг олгож байна.

Өрх: Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг “өрх” гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно. Өрх нь гэр бүл гэдэг ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдардаг байж болно.

Өрхийн тэргүүлэгч: Өрхийн тэргүүлэгч гэдэг нь бусад гишүүд нь өрхийн тэргүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн өрхийн гишүүн бөгөөд насанд хүрсэн хүн байна. Хэрвээ тухайн сууцанд нэгээс олон өрх амьдран сууж байвал тэдий тооны өрхийн тэргүүн байна.

Хөдөлмөрийн статистик: Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тодорхойлох, дүн шинжилгээ хийхэд ашигладаг тоон мэдээллийн багц юм.

Эдийн засгийн үйл ажиллагаа: Зах зээлд болон хувийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг хамруулна. Үндэсний тооцооны системийн хүрээнд бараа, үйлчилгээнд худалдах, солилцох, өөрийн аж ахуйд хэрэглэх зорилгоор боловсруулсан түүхий эд материал, зах зээлд нийлүүлж байгаа бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээлд худалдах, өөртөө хэрэглэх зорилгоор өрхөд үйлдвэрлэж байгаа бараа, үйлчилгээг хамруулна. Энэ нь цалин хөлстэй болон цалин хөлсгүй, албан болон албан бус хэлбэртэй байж болно. Жишээлбэл, өөрийн өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцож буй хүнийг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байна гэж ойлгоно.

Эдийн засгийн бус үйл ажиллагаа: Хүүхэд, өндөр настан асрах, гэр цэвэрлэх, хоол унд бэлтгэх зэрэг цалин хөлс, орлого олохгүй үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- Гэр орон цэвэрлэх, хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах;
- Хувцас угаах, индүүдэх, гэр байшин, эд хогшил сэргээн засах;
- Хоол унд хийх, аяга таваг угаах;
- Хүүхэд асрах;

- Өвчтэй хүн, өндөр настан асрах;
- Гэрийнхээ хэрэгцээт зүйлийг худалдаж авах, дэлгүүр явах гэх мэт.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч): Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ыг эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилна.

Эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам: Урт хугацаагаар буюу сүүлийн арван хоёр сарын хугацаанд үндсэн үйл ажиллагааны шинж байдлаараа ажиллаж байсан болон ажилгүй байсан хөдөлмөрийн насны хүн амыг хамруулна.

Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам: Сүүлийн долоо хоногт эрхэлсэн үндсэн үйл ажиллагааны шинж байдлаараа ажиллаж байсан болон ажилгүй байсан нь тодорхойлогдох ажиллагч болон ажилгүй иргэдийг хамруулна.

Эдийн засгийн идэвхгүй хүн ам: Эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны нийт хүн ам болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн ам, хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон хүн ам, хөдөлмөрийн чадвараа зургаан сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн, хөдөлмөрийн насны өдрөөр суралцагч, хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амыг эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам гэж хоёр ангилна.

Эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам: Урт хугацаагаар буюу сүүлийн арван хоёр сарын хугацаанд эрхэлсэн үндсэн үйл ажиллагаагаараа эдийн засгийн идэвхтэй хүн амд тооцогдохгүй (ажиллагч болон ажилгүй иргэнд хамаарахгүй) хүн амыг, тухайлбал оюутан, сурагч, гэрийн ажилтай болон өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хүн амыг хамруулна.

Эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам: Сүүлийн долоо хоногт сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон болон өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагч болон ажилгүй иргэдийн алинд ч хамаарахгүй хүн амыг хамруулна.

Ажиллагч: Ажиллагч гэдэг нь цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг ойлгоно. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн статус: Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тухайн хүний ажиллаж байгаа байгууллага, бусад хүмүүстэй харьцах эрх мэдэл, ажил үүрэг, хүлээх хариуцлагаар тодорхойлогдоно.

Цалин хөлстэй ажиллагч: Хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг иргэнийг хэлнэ.

Ажил олгогч: Эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хэлнэ.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч: Дангаараа буюу бусадтай хамтран өөрийн багаж, тоног төхөөрөмж, бусад материалыг ашиглан эдийн засгийн үйл ажиллагааг хараат бусаар явуулж, урт хугацаагаар ажилтан авч ажиллуулдаггүй (харин богино хугацаагаар түр авч ажиллуулж болно), бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрийг бие даан гаргадаг иргэнийг хэлнэ.

Мал аж ахуй эрхлэгч: Жилийн дөрвөн улирлын туршид өөрийн мал аж ахуйг эрхэлж, түүний бүтээгдэхүүн, ашиг шимээр орлого олж, амьжиргааны эх үүсвэрээ хангаж буй иргэнийг хэлнэ.

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч: Мал аж ахуйгаас бусад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцон, хувийн хэрэглээгээ хангаж буй тухайн өрхийн гишүүн болон тухайн өрхөд хамт амьдрахгүйгээр аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд нь оролцож байгаа иргэнийг хэлнэ.

Ажил хайгч иргэн: Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг хэлнэ.

Ажилгүй иргэн: Тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

а/ “ажилгүй байсан” гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж орлого олоогүй байхыг;

б/ “ажил хийхэд бэлэн” гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

в/ “ажил идэвхтэй хайж байгаа” гэж ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

Урт хугацаагаар ажилгүй байгаа иргэн: Зургаан сар буюу түүнээс дээш хугацаагаар хөдөлмөр эрхлээгүй, ажилгүй иргэнийг хэлнэ.

Ажил хийгээгүй болон суралцаагүй байгаа залуучууд: Тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй, албан боловсрол эзэмших сургуульд суралцаагүй, бүх шатны сургалтад хамрагдаагүй байгаа 15-24 насны ажилгүй болон ажиллах хүчнээс гадуурх залуучуудыг ойлгоно.

Үндсэн ажил: Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол ач холбогдол болон цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлыг тодорхойлно. Хэрвээ тухайн хүн зөвхөн нэг л ажил эрхэлдэг бол түүнийг үндсэн ажилд тооцно.

Давхар ажил: Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол ач холбогдол болон цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлаас бусад ажлыг давхар ажил гэж ойлгоно.

Албан бус хөдөлмөр эрхлэгч: Албан ёсны бүртгэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хөдөө аж ахуйн бус бөгөөд хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээ эрхэлж буй иргэдийг хамруулна. Мөн Монгол Улсын Их Хурлын “Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого батлах тухай” 2006 оны 1 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.3-т “Албан

бус хөдөлмөр эрхлэлт гэдэгт албан ёсны бүртгэл, мэдээлэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, хөдөө аж ахуйн бус, аж ахуй эрхлэх аливаа нэгэн зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээг хувь хүн, өрх, хамтлаг эрхлэхийг хамруулна” гэж заасан.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт: Тухайн хугацаанд нэмэлт цагаар ажиллахыг хүссэн, ажиллаж буй ажлын цаг нь тогтоосон хугацаанаас доогуур, нэмэлт ажил хийх боломжтой байгаа ажиллагчдыг цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхэлж байгаа гэж ойлгоно.

Жинхэнэ ажилласан цаг: Тайлант хугацаанд, урт болон богино хугацааны туршид бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулсан хугацаа юм. Үндэсний тооцооны системийн хүрээнд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан үйл ажиллагааны жинхэнэ ажилласан цагт дараах цагуудыг ойлгоно. Үүнд:

- Шууд цаг: Ажлын үүрэг, даалгаврыг гүйцэтгэхэд зарцуулсан цаг;
- Хамааралтай цаг: Бүтээлч үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэхэд зарцуулах цаг;
- Ашиглаагүй цаг: Ажлын байран дээрээ байгаа боловч техникийн саатлаас тухайлбал, гэрэл тасрах, интернетийн шугам тасрах, машин техник эвдрэх, осол гаргах зэрэг шалтгаанаар ажиллаж чадахгүй байх цаг;
- Амрах цаг: Зан заншил, хэм хэмжээ тогтоосон гэрээний дагуу эсвэл улс үндэстний нөхцөл байдалтай холбоотойгоор мөргөл үйлдэх, түр амс хийх, кофе цай уух, хүч сэлбэх зэрэг богино хугацааны амралтад зориулсан цагийг хамруулан ойлгоно.

Байнгын ажлын цаг: Урт удаан ажиглалтын хугацаанд ажилд хамгийн түгээмэл ажилласан цаг.

## 2.2 АРГАЧЛАЛ

Ажиллах хүчний оролцооны түвшин: Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажиллах хүчний оролцооны түвшин} = \frac{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн амын тоо}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

Ажилгүйдлийн түвшин: Ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажилгүйдлийн түвшин} = \frac{\text{Ажилгүй иргэдийн тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

Урт хугацааны ажилгүйдлийн түвшин: Урт хугацаагаар ажилгүй байгаа иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Урт хугацааны ажилгүйдлийн түвшин} = \frac{\text{Урт хугацаагаар ажилгүй байгаа иргэдийн тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

Эдийн засгийн идэвхтэй, идэвхгүй хүн амыг тодорхойлох схем



Албан бус хөдөлмөр эрхлэлтийг тодорхойлох схем



# БҮЛЭГ III

# СУДЛГААНЫ ТОВЧ ДҮН

30

## 3.1 ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ

1 АХС-г өрхөд суурилсан түүврийн аргаар явуулж, хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлтүүдийг улирлаар тархаан тооцож, үр дүнг танилцуулж байна. Судалгаанд нийт 12816 өрх/сард 1068, улиралд 3204 өрх/ сонгогдсоноос бүх өрх хамрагдаж, хамрагдалтын түвшин 100 хувьтай гарав. Судалгаанд нийтдээ 44260 хүн хамрагдаж асуулгад хариулсан.

2 Улсын хэмжээнд нийт өрхийн 749.4 (80.3%) мянган өрхөд цалин хөлс орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа гишүүд байна. Улсын хэмжээнд ажилгүй иргэнтэй өрхийн 26.4 (28.6%) мянга нь 4 ам бүлтэй байна.

## 3.2 ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ

3 Ажиллах хүч буюу 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1358.6 мянга байгаагаас 730.6 (53.8%) мянга нь эрэгтэй, 628.0 (46.5%) мянга нь эмэгтэйчүүд байна. Мөн эдийн засгийн идэвхтэй хүн амын 1253.0 (92.2%) мянга нь ажиллагчид, 105.6 (7.8%) мянга нь ажилгүй иргэд байна.

4 Ажиллах хүчний оролцооны түвшин /АХОТ/ улсын хэмжээнд 61.0 хувь, хотод 55.4 хувь, харин хөдөөд үүнээс нэлээд өндөр 72.3 хувьтай байна.

5 Эдийн засгийн идэвхгүй хүн ам 868.0 мянга байгаагаас 320.7 (36.9%) мянга нь эрэгтэй, 547.3 (6.1%) мянга нь эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амыг шалтгаанаар нь авч үзэхэд тэтгэвэрт байгаа, өндөр настан хүмүүс 280.0 мянга, сурахаар явах гэж байгаа болон суралцагчид 261.1 мянга, хүүхэд асарсан 117.2 мянга, гэрийн ажилтай 71.1 мянга, хөгжлийн бэрхшээлтэй 68.5 мянга, өвчтэй 21.1 мянга, өвчтөн, өндөр настан асарсан 12.9 мянга, хөдөлмөр эрхлэхийг хүсээгүй 11.3 мянга, бусад шалтгаантай 24.8 мянган хүн байна. Мөн хот, хөдөөгөөр авч үзэхэд, 663.7 (76.5%) мянга нь хот, суурин газарт, 204.3 (23.5%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна.

6 Хөдөө орон нутагт эдийн засгийн идэвх өндөр байгаа нь хөдөөгийн тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй хүн амын тоог багасгажээ. Хөдөө орон нутгийн эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо хот, суурин газрын эдийн засгийн идэвхгүй хүн амын хагаст нь ч хүрэхгүй доогуур байна. Хөдөө орон нутагт АХОТ хотынхоос өндөр байгаа нь өрхийн аж ахуйд суурилсан нүүдлийн мал аж ахуйн онцлогтой холбоотой байж болох юм.

## 3.3 АЖИЛЛАГЧИД

7 Судалгааны дүнгээр улсын хэмжээнд нийт 1253.0 мянган хүн хөдөлмөр эрхэлсний 669.6 (53.4%) мянга нь эрэгтэйчүүд, 583.4 (46.6%) мянга нь эмэгтэйчүүд байна. Тухайн үеийн ажиллагчдын 746.7 (59.6%) мянга нь хот, суурин газарт, 506.3 (40.4%) мянга нь хөдөө орон нутагт байна.

8 Ажиллагчдын 327.9 (26.2%) мянга нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан, 229.4 (18.3%) мянга нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 205.1 (16.4%) мянга нь мэргэжилтэн, 131.3 (10.5%) мянга нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 114.5 (9.1%) мянга нь машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагчийн ажил мэргэжлээр ажиллаж байна. Харин хүйсээр ялган харахад суурин төхөөрөмж, машин, механизмын операторч, угсрагчаар ажиллагчдын хувьд эрэгтэйчүүд өндөр хувьтай байгаа бол контор, үйлчилгээний ажилтнаар ажиллагчдын дунд эмэгтэйчүүд илүү өндөр хувьтай байна.

9 Ажиллагчдын 334.1 (26.7%) мянга нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын, 211.2 (16.9%) мянган нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 100.8 (8.0%) мянга нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажилласан байна. Хүйсээр салбарын ялгааг гарган харуулахад уул уурхай, барилга, олборлолт болон тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, барилга, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын ихэнх нь (51.0-84.0 хувь) эрэгтэйчүүд байхад бусад 12 салбарт ажиллагчид болон бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсрол болон хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын талаас илүү хувь нь (56.6-81.8 хувь) эмэгтэйчүүд байна.

10 Ажиллагчдын 39.3 хувийг гэрээгээр ажиллагчид, 35,0 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 24,8 хувийг өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчид эзэлж байна. Хоршооллын гишүүд болон ажил олгогчид дөнгөж 0.2- 0,6 хувийг эзэлж байна. Тухайн үед өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын ихэнх нь буюу 61.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Ажил олгогч арван хүний ес нь, хувиараа хөдөлмөр эрхлэгч таван хүний гурав нь эрэгтэйчүүд байхад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч таван хүний бараг дөрөв нь эмэгтэйчүүд байна.

11 Ажиллагчдын 39,3 хувийг гэрээгээр ажиллагчид, 35,0 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 24,8 хувийг өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчид эзэлж байна. Хоршооллын гишүүд болон ажил олгогчид дөнгөж 0.2- 0,6 хувийг эзэлж байна.

Тухайн үед өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын ихэнх нь буюу 61.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

12 Ажиллагчдын 220.0 (17.6%) мянга нь албан бус салбарт ажиллаж байна. Тэдгээрийн 75.1 хувь нь хот, суурин газарт, 24.9 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Албан бус салбарт ажиллаж буй ажиллагчдын ихэнх хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ (95.6 мянга буюу 43.4%)-ний салбарт ажиллаж байгаа бол ажил мэргэжилийн хувьд худалдаа, үйлчилгээний ажилтны мэргэжил (97.3 мянга буюу 44.3%)-ээр ихэнх нь ажиллаж байна.

13 Ажиллагчдын 35.4 (2.8%) мянга нь богино (долоо хоногт 25 хүртлэх) цагаар, 349.1 (27.9%) мянга нь урт (долоо хоногт 60-аас дээш) цагаар ажиллаж байна. Мөн нийт ажиллагчдын 598.4 (47.8%) мянга нь илүү (долоо хоногт 48 цагаас илүү) цагаар ажиллаж байна. Зохистой хөдөлмөр эрхлэлтийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уртасгасан болон хэт их цагаар үргэлжлүүлэн ажиллах нь хүний бие, мах бод, сэтгэл санаа, эрүүл мэндэд хохирол учруулахаас гадна энэ нь ажил болон гэр бүлийн амьдралын хоорондын тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж, улмаар ажлын бүтээмжийг бууруулдаг гэж үздэг. Харин бага цагаар ажиллах нь хөдөлмөрлөх эрх боломж хангалтгүй байгааг харуулдаг.

14 Нийт 8.1 мянган ажиллагчид цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын өөр (ажилгүй иргэдээс гадна) нэг нь уг үзүүлэлт бөгөөд эдийн засгийн идэвхтэй хүн амд эзлэх хувь 0.7, ажиллагчдад эзлэх хувь 0.6 байна.

## 3.4 УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ

15 Судалгааны үр дүнг улирлаар авч үзэхэд 15 ба түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх өвөл, зуны буюу 1,3 дугаар улиралд бага, 2,4 дүгээр улиралд их байсан байна.

16 Судалгааны 2 дугаар улиралд үйлчилгээний салбар их өсөлттэй /ХАА, үйлдвэрлэл мөн өсөлттэй/, 4 дүгээр улиралд ХАА-н салбар дахь эдийн засгийн үйл ажиллагаа өссөн байна. Энэ нь хавар, намрын улиралд манай орны онцлог барилга, уул уурхай гэх мэт үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон хөдөө аж ахуйн үйл ажиллагаа өргөжих таатай боломж бүрддэг, үүнтэй холбоотой тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа ихэсдэг байж болох талтай юм.

## 3.5 АЖИЛГҮЙ ИРГЭД

17 Улсын хэмжээнд нийт ажилгүй иргэд 105.6 мянга байгаагийн 60.9 (57.7%) мянга нь эрэгтэйчүүд, 44.7 (42.3%) мянга нь эмэгтэйчүүд байна. Ажилгүйдлийн түвшин

улсын хэмжээнд 7.8 хувь, эрэгтэйчүүдийнх 8.3 хувь, эмэгтэйчүүдийнх 7.1 хувь байгаа бол байршлын хувьд хотод 9.4 хувь, хөдөөд харьцангуй бага буюу 5.2 хувьтай байна.

18 Ажилгүй иргэдийг насны бүтцээр нь харахад ихэвчлэн залуу хүмүүс, ялангуяа ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орогчид ажилгүйдэлд илүү өртөж байна. Нийт ажил эрхлээгүй хүн амын 56.1 хувь нь 15-34 насныхан, 19.5 хувь нь ажиллах хүчинд шинээр элсэн орсон 20-24 насныхан байна. Нийт ажилгүй иргэдийн 25.3 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байна.

19 Нийт ажилгүй иргэдийн 77.7 (73.5%) мянга нь урт хугацаагаар (6-н сараас дээг), 65.3 (61.8%) мянга нь 12, түүнээс дээш сараас ажил хийх боломжтой байсан байна.

20 Нийт ажилгүй иргэдийн 72.6 (68.8%) мянга нь тодорхой хэмжээний мэргэжил эзэмшсэн байхад дунд боловсролгүй болон түүнээс доош боловсролтой иргэдийн эзлэх хувь нилээд бага буюу 33 (28.9%) мянга байна.

21 Ажилгүй иргэдийн ихэнх нь 51.2 (48.5%) мянга нь ажил хайгаад олдохгүй байгаа, 13.6 (12.9%) мянга нь мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа, 10.0 (9.4%) мянга нь мэргэжил, дадлага туршлага байхгүй байгаагаас ажил олдохгүй байна гэж хариулсан байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг хангасан эрэлт, хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх нь чухал байгааг харуулж байна.

# БҮЛЭГ IV

# ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## 18, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал



36

## 4.1. ӨРХ, ХҮН АМ ЗҮЙ

Манай улсын нийт хүн ам 2018 оны байдлаар 3238.5 мянга, нийт өрх 894.5 мянга байна. Нийт хүн амын 212.2 (6.5%) мянга нь 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байна. Эдгээр хүмүүс нь нийт өрхийн 15.7 хувь буюу 140.7 мянган өрхийн гишүүд байна.

Судалгааны тархаалтын тооцоогоор 6 сараас дээш хугацаагаар өрхөөсөө гадуур амьдарч байгаа өрхийн гишүүнтэй 140.7 мянган өрх дунджаар нэг өрхөөс бараг 2 хүн нь 6 сараас дээш хугацаагаар өрхөөсөө гадуур амьдарч байна гэсэн дүн гарч байна.

Улсын хэмжээнд нийт өрхийн 749.4 (80.3%) мянган өрхөд цалин хөлс орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа гишүүд байна. Нийт ажиллагчдын 347.3 (27.7%) мянга нь 4 ам бүлтэй өрхийн гишүүн байна.

Ажиллагчдыг өрхөд нь ажиллаж буй хүнээр авч үзэхэд ажил эрхэлдэг 4 хүнтэй өрх 47.0 хувь, зөвхөн тухайн ажиллагч л буюу ажил эрхэлдэг 1 хүнтэй өрх 44.0 хувь, ажил эрхэлдэг 3 хүнтэй өрх 7.3 хувь бол 4 гишүүн нь ажилладаг өрх 1.7 хувийг эзэлж байна.

**Зураг 4.1. Ажил эрхэлдэг иргэнтэй өрх, өрхийн ам бүл, өрхөд ажил эрхэлж байгаа хүнээр**




Улсын хэмжээнд ажилгүй иргэнтэй өрхийн 26.4 (28.6%) мянга нь 4 ам бүлтэй байна. Эдгээр өрхийн 91.2 хувьд нь тухайн өрхийн нэг хүн ажилгүй, 8.1 хувьд нь 2 хүн ажилгүй, 0.6 хувьд нь 3 хүн нь ажилгүй, 0.1 хувьд нь 4 болон түүнээс дээш хүн ажилгүй, ажил хийхэд бэлэн эсвэл хайж байгаа гэсэн дүр зураг харагдаж байна.

**Зураг 4.2. Ажилгүй иргэнтэй өрх, өрхийн ам бүл, өрхөд ажилгүй байгаа хүнээр**




## 4.2. ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Судалгаагаар олон улсын аргачлалын дагуу 15, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдлыг авч үздэг ч манай улсын хуульд нийцүүлэн 18, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдлыг гэрлэсэн /батлуулсан, батлуулаагүй/, огт гэрлээгүй, тусгаарласан, цуцалсан, бэлбэсэн гэсэн 6 бүлгээр авч үзсэн.

Манай улсын 18, түүнээс дээш насны нийт хүн амын 66.7 хувь нь гэрлэсэн, 20.5 хувь нь огт гэрлээгүй, 8.5 хувь нь бэлбэсэн хүмүүс байна.

**Зураг 4.3. 18, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, хувиар**



## 4.3. БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин 98.3 хувь байсан бол 2018 оны судалгаагаар хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин 99.1% болж 0.8 пунктээр өссөн байна.

15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин хөдөөд 98.2 хувь байхад хотод (99.4%) буюу 1.2 пунктээр дээгүүр байна.

Бүрэн дунд, тусгай мэргэжлийн дунд, дипломын болон бакалаврын дээд боловсролтой эмэгтэйчүүдийн нийт дунд эзлэх хувь (1.6-9.8 пунктээр илүү) байхад, харин техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс (11.5 пунктээр илүү) байна.

Хүснэгт 4.1. 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, байршил, хүйсээр, дунд эзлэх хувиар

| Боловсролын түвшин | Нийт | | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Эрэгтэй | Эмэгтэй | Эрэгтэй | Эмэгтэй |
| Боловсролгүй | 7.5 | 8.6 | 6.5 | 2.7 | 2.3 | 19.5 | 15.7 |
| Бага | 2.2 | 2.0 | 2.3 | 1.2 | 1.6 | 3.5 | 3.8 |
| Суурь | 13.1 | 14.3 | 12.2 | 9.5 | 8.7 | 23.4 | 19.7 |
| Бүрэн дунд | 19.6 | 18.8 | 20.4 | 19.3 | 19.9 | 17.8 | 21.4 |
| Техинкийн болон мэргэжлийн | 23.5 | 29.5 | 18.1 | 33.7 | 20.2 | 21.6 | 13.4 |
| Тусгай мэргэжлийн дунд | 6.4 | 4.6 | 7.9 | 4.7 | 8.5 | 4.4 | 6.7 |
| Дипломын болон бакалаврын дээд | 25.9 | 20.7 | 30.5 | 26.8 | 36.0 | 9.5 | 18.7 |
| Магистр ба түүнээс дээш | 1.8 | 1.5 | 2.1 | 2.1 | 2.8 | 0.3 | 0.6 |
| Дүн, % | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15, түүнээс дээш насны хүн ам | 2 226 596 | 1 051 276 | 1 175 320 | 685 137 | 802 953 | 366 138 | 372 367 |

Боловсролын түвшинг, хүйс, байршлаар авч үзвэл хотын эрэгтэйчүүдийн 33.9 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой байхад хөдөөгийн эрэгтэйчүүдийн 23.4 хувь нь суурь боловсролтой байна. Харин хотын эмэгтэйчүүдийн 36.0 хувь нь дипломын болон бакалаврын дээд боловсролтай байхад хөдөөгийн эмэгтэйчүүдийн 21.4 хувь нь бүрэн дунд  боловсролтой байна.

**Зураг 4.4. 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, байршлаар**




15 түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшинг, байршлаар харвал боловсролгүй, бага болон суурь боловсролтой хүн амын тоо хөдөөд хотынхоос их байхад бусад боловсролын хувьд хотод хөдөөгийнхөөс өндөр байна.

# БҮЛЭГ V
# ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ



## 5.1 ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Судалгааны дүнгээр 15, түүнээс дээш насны 2226.6 мянган хүн байгаагийн 1051.3(47.2%) мянга нь эрэгтэй, 1175.3(52.8%) мянга нь эмэгтэйчүүд, 15, түүнээс дээш насны нийт хүн амын 1358.6(61.0%) мянга нь эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам байна.

**Хүснэгт 5.1. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, байршил, хүйсээр**

| Байршил | Бүгд | | Хүйсээр | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % |
| Улсын хэмжээнд | | | | | | |
| Тухайн үеийн идэвхтэй хүн ам | 1 358 637 | 61.0 | 730 591 | 69.5 | 628 046 | 53.4 |
| Ажиллагчид | 1 253 023 | 56.3 | 669 643 | 63.7 | 583 380 | 49.6 |
| Ажилгүй иргэд | 105 614 | 4.7 | 60 948 | 5.8 | 44 666 | 3.8 |
| Тухайн үеийн идэвхгүй хүн ам | 867 959 | 39.0 | 320 685 | 30.5 | 547 274 | 46.6 |
| 15, түүнээс дээш насны хүн ам | 2 226 596 | 100.0 | 1 051 276 | 100.0 | 1 175 320 | 100.0 |
| Хот | | | | | | |
| Тухайн үеийн идэвхтэй хүн ам | 824 365 | 55.4 | 444 289 | 64.9 | 380 076 | 47.3 |
| Ажиллагчид | 746 679 | 50.2 | 398 538 | 58.2 | 348 141 | 43.3 |
| Ажилгүй иргэд | 77 686 | 5.2 | 45 751 | 6.7 | 31 935 | 4.0 |
| Тухайн үеийн идэвхгүй хүн ам | 663 724 | 44.6 | 240 848 | 35.1 | 422 876 | 52.7 |
| 15, түүнээс дээш насны хүн ам | 1 488 089 | 100.0 | 685 137 | 100.0 | 802 952 | 100.0 |
| Хөдөө | | | | | | |
| Тухайн үеийн идэвхтэй хүн ам | 534 272 | 72.4 | 286 302 | 78.2 | 247 970 | 66.6 |
| Ажиллагчид | 506 344 | 68.6 | 271 105 | 74.0 | 235 239 | 63.2 |
| Ажилгүй иргэд | 27 928 | 3.8 | 15 197 | 4.2 | 12 731 | 3.4 |
| Тухайн үеийн идэвхгүй хүн ам | 204 235 | 27.6 | 79 837 | 21.8 | 124 398 | 33.4 |
| 15, түүнээс дээш насны хүн ам | 738 507 | 100.0 | 366 139 | 100.0 | 372 368 | 100.0 |
| Улсын хэмжээнд | | | | | | |
| АХОТ* | | 61.0 | | 69.5 | | 53.4 |
| Хөдөлмөр эрхлэлтийн түвшин | | 56.3 | | 63.7 | | 49.6 |
| Ажилгүйдлийн түвшин | | 7.8 | | 8.3 | | 7.1 |
| Хот | | | | | | |
| АХОТ* | | 55.4 | | 64.8 | | 47.3 |
| Хөдөлмөр эрхлэлтийн түвшин | | 50.2 | | 58.2 | | 43.4 |
| Ажилгүйдлийн түвшин | | 9.4 | | 10.3 | | 8.4 |
| Хөдөө | | | | | | |
| АХОТ* | | 72.3 | | 78.2 | | 66.6 |
| Хөдөлмөр эрхлэлтийн түвшин | | 68.6 | | 74.0 | | 63.2 |
| Ажилгүйдлийн түвшин | | 5.2 | | 5.3 | | 5.1 |

**АХОТ = Ажиллах хүчний оролцооны түвшин*

2018 онд 1358.6 мянган эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам байсны 1253.0 (92.2%) мянга нь ажиллагчид, харин 105.6 (7.8%) мянга нь ажилгүй иргэд байна. Нийт эдийн засгийн идэвхтэй хүн амын 60.7 хувь нь хот, суурин газарт, 39.3 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна.

## 5.2 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН

Ажиллах хүчний 2018 оны судалгаагаар АХОТ улсын хэмжээнд 61.0 хувь, хот суурин газарт 55.4 хувь хөдөөд үүнээс харьцангуй өндөр 72.3 хувьтай байна. Хот, суурин газарт АХОТ нь хөдөө орон нутгийнхнаас 16.9 пунктээр доогуур (эрэгтэйчүүдийнх 13.4 пунктээр, эмэгтэйчүүдийнх 19.3 пунктээр) байгаа нь хот, суурин газарт сургуульд хамрагдалтын түвшин хөдөө орон нутгийнхнаас өндөр байдагаас шалтгаалж болно. Хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийн АХОТ өндөр байгаа нь улсын хэмжээний түвшинд нөлөөлжээ.

**Зураг 5.1. Ажиллах хүчний оролцооны түвшин, байршил, хүйсээр**




### 5.2.1 Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлгээр

АХОТ-г тооцсноор хүн амын хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцооны өөрчлөлт, хөдөлгөөн насны бүлгээр хэрхэн өөрчлөгдөж буйг харах боломжийг бий болдог. Ажиллах хүчний оролцооны түвшин 15-19 насанд 10.6 хувь байсан бол 20-24 насанд даруй өсч 52.9 хувь, 25-29 насанд 73.7 хувь, 30-49 насанд 80.8-84.4 хувь болж өссөн байна. 50-54 насны бүлгээс эхлэн аажмаар буурч, 55-59 насанд 48.5, 60-64 насанд 21.1 хувь болсон байна. Насны бүлэг дэх АХОТ нь 40-44, 45-49 насанд хамгийн өндөр буюу 84.4 хувьтай байна.

**Зураг 5.2. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр**



Эрэгтэйчүүдийн АХОТ эмэгтэйчүүдийнхээс 15-19, 40-49 болон 60-аас дээш насанд харьцангуй ойролцоо буюу 5.3-10.5 пунктын зөрүүтэй, 25-39 насанд 16.0-25.6 пунктээр илүү байна. Эмэгтэйчүүд энэ насанд хүүхэд төрүүлэх, асрах зорилгоор ажиллах хүчний эгнээнээс гардаг бөгөөд хүүхдүүд нь өсч томрохын хирээр ажиллах хүчний эгнээнд эргэн ордог байна. Харин 55-59 насанд хамгийн өндөр буюу 30.8 пунктын зөрүүтэй байгаа нь хөдөлмөрийн хуулийн дагуу эмэгтэй 55, эрэгтэй 60-аас дээш насны хүмүүс тэтгэвэрт гардагтай холбоотой.

**Зураг 5.3. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, байршлаар**




Хөдөө орон нутагт өрхийн аж ахуйд суурилсан нүүдлийн мал аж ахуй эрхлэлт давамгайлж, мөн сургууль, боловсролын үйлчилгээний хүртээмж харьцангуй бага байдагаас хөдөө орон нутгийн АХОТ өндөр гарч байна.

### 5.2.2 Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшнээр

Зураг 5.4-өөс харахад хүйс харгалзахгүйгээр боловсролын түвшин дээшлэх тутам ажиллах хүчний оролцооны түвшин өсч байна. Хүйсээр авч үзэхэд, доктороос бусад бүх шатанд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс их байна. Мөн ажиллах хүчний оролцооны түвшинд тухайн хүний эзэмшсэн боловсролын түвшин нөлөөлдөг болох нь харагдаж байна.

**Зураг 5.4. Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшнээр**




### 5.2.3 Ажиллах хүчний оролцооны түвшин, гэрлэлтийн байдлаар

Эдийн засгийн идэвхтэй 18, түүнээс дээш насны хүмүүсийн АХОТ нь гэрлэлтийн байдлаас хэрхэн хамааралтай болохыг судалж үзэхэд бэлбэсэн, гэр бүлээ цуцалсан хүмүүсийн АХОТ нь хүйс харгалзахгүйгээр ойролцоо бол бусад гэрлэлтийн байдалд хүйсээрээ ялгаатай байна.

**Зураг 5.5. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, гэрлэлтийн байдлаар**




Гэр бүл цуцалсан эмэгтэйчүүдийн АХОТ бусад бүлгийн эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа бол бэлбэсэн хүмүүсийн АХОТ бага байгаа нь тэдний настай холбоотой. Нас ахих тусам ажиллах хүчний оролцооны түвшин багасдаг хандлага нөлөөлсөн байх талтай.

## 5.3 ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ

Судалгаагаар 15, түүнээс дээш насны нийт 2226.6 мянган хүний 868.0(39.0%) мянга нь эдийн засгийн идэвхгүй хүн амын бүлэгт багтаж байгаагийн 320.7 мянга нь эрэгтэйчүүд, 547.3 мянга нь эмэгтэйчүүд байна.

**Зураг 5.6. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, байршлаар**




Эдийн засгийн идэвхгүй хүн амыг шалтгаанаар нь авч үзэхэд тэтгэвэрт байгаа, өндөр настан хүмүүс 280.0 мянга, сурахаар явах гэж байгаа болон суралцагчид 261.1 мянга, хүүхэд асарсан 117.2 мянга, гэрийн ажилтай 71.1 мянга, хөгжлийн бэрхшээлтэй 68.5 мянга, өвчтэй 21.1 мянга, өвчтөн, өндөр настан асарсан 12.9 мянга, хөдөлмөр эрхлэхийг хүсээгүй 11.3 мянга, бусад шалтгаантай 24.8 мянган хүн байна.

**Зураг 5.7. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар, хувиар, хүйсээр**



**Зураг 5.8. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам, зарим шалтгаанаар, хүйсээр, хувиар**




2017 онд эдийн засгийн идэвхгүй байгаа нийт эмэгтэйчүүдийн 101.0(19.6%) мянга нь хүүхэд асарч байсан бол энэ үзүүлэлт 2018 онд 109.5(20.0%) мянга болж 0.4 пунктээр өссөн байна. Харин гэрийн ажилтай байсан эмэгтэйчүүд 52.6(9.6%) мянга болж өмнөх оны үр дүнгээс 0.6 пунктээр өссөн байна. Байршлаар харахад хүүхдээ асарч буй хөдөөгийн эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2017 оноос 1.8 пунктээр өссөн байна.

**Хүснэгт 5.2. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам, насны бүлгээр, шалтгаанаар, хувиар**

| Насны бүлэг | Гэрийн ажилтай | Суралцдаг сурахаар явах гэж байгаа | Тэтгэвэрт өндөр настан | Хөгжлийн бэрхшээл-тэй | Ажил хийхийг хүсээгүй | Хүүхэд асарсан | Өвчтэй байсан | Өвчтөн, өндөр настан асарсан | Бусад | Улсын хэмжээнд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 - 19 | 9.3 | 73.6 | - | 4.1 | 6.9 | 2.2 | 2.0 | 1.5 | 11.4 | 24.0 |
| 20 - 24 | 8.2 | 22.7 | - | 7.3 | 16.3 | 13.0 | 4.3 | 5.3 | 23.7 | 10.9 |
| 25 - 29 | 11.2 | 3.1 | - | 7.5 | 14.4 | 28.1 | 8.6 | 9.0 | 13.7 | 7.2 |
| 30 - 34 | 12.1 | 0.5 | - | 7.0 | 3.0 | 25.0 | 9.1 | 10.1 | 10.4 | 5.8 |
| 35 - 39 | 11.1 | 0.1 | - | 9.6 | 11.5 | 15.9 | 15.0 | 6.6 | 9.2 | 4.7 |
| 40 - 44 | 13.7 | - | - | 15.4 | 8.8 | 8.4 | 12.3 | 15.7 | 8.3 | 4.4 |
| 45 - 49 | 15.1 | - | 0.7 | 13.7 | 9.8 | 3.4 | 12.3 | 13.0 | 9.7 | 3.9 |
| 50 - 54 | 13.3 | - | 4.6 | 20.8 | 17.6 | 3.2 | 23.8 | 28.0 | 7.5 | 6.1 |
| 55 - 59 | 5.7 | - | 21.5 | 11.6 | 10.7 | 0.8 | 11.4 | 5.0 | 5.5 | 9.0 |
| 60 - 64 | 0.3 | - | 28.0 | 3.0 | 1.0 | - | 0.5 | - | 0.6 | 9.3 |
| 65 - 69 | - | - | 16.1 | - | - | - | - | 1.8 | - | 5.2 |
| 70 + | - | - | 29.1 | - | - | - | 0.7 | 4.0 | - | 9.5 |
| Дүн, (%) | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |

15, түүнээс дээш насны хүн амын 867.9(39.0%) мянга нь эдийн засгийн идэвхгүй хүн ам байгаагын 365.1(42.1%) мянгыг 15-29 насны залуучууд, 287.1(33.0%) мянгыг 55, түүнээс дээш насны буюу тэтгэврийн насны хүмүүс эзлэж байна.

# БҮЛЭГ VI

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



50

## 6.1 ТУХАЙН ҮЕИЙН АЖИЛЛАГЧИД

Судалгааны дүнгээр улсын хэмжээнд нийт 1253.0 мянган хүн хөдөлмөр эрхэлсний 669.6 (53.4%) мянга нь эрэгтэйчүүд, 583.4 (46.6%) мянга нь эмэгтэйчүүд байна.

**Хүснэгт 6.1. Ажиллагчид, байршил, бүс, хүйсээр**

| Байршил/ Бүс | Бүгд | | Хүйсээр | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % |
| Улсын дүн | 1 253 023 | 100.0 | 669 643 | 100.0 | 583 380 | 100.0 |
| Хот | 746 679 | 59.6 | 398 538 | 59.5 | 348 141 | 59.7 |
| Хөдөө | 506 344 | 40.4 | 271 105 | 40.5 | 235 239 | 40.3 |
| Баруун | 176 523 | 14.1 | 94 810 | 14.2 | 81 713 | 14.0 |
| Хангайн | 260 673 | 20.8 | 139 175 | 20.8 | 121 498 | 20.8 |
| Төвийн | 216 377 | 17.3 | 112 666 | 16.8 | 103 711 | 17.8 |
| Зүүн | 86 397 | 6.9 | 46 864 | 7.0 | 39 533 | 6.8 |
| Улаанбаатар | 513 053 | 40.9 | 276 128 | 41.2 | 236 925 | 40.6 |

Тухайн үеийн ажиллагчдын 746.7 (59.6%) мянга нь хот, суурин газарт, 506.3 (40.4%) мянга нь хөдөө орон нутагт байна.

**Зураг 6.1. Ажиллагчид, байршил, хүйсээр**




Тухайн үед хөдөлмөр эрхэлсэн нийт хүн амын 513.1 (40.9%) мянга нь нийслэл хотод, харин 319.7 (27.5%) мянга нь дараах 7 аймагт (Хөвсгөл – 57.2 (4.6%), Өвөрхангай – 29.7 (4.5%), Төв – 49.7 (4.0%), Баян-Өлгий - 48.8 (3.9%), Сэлэнгэ – 48.9 (3.7%), Архангай – 43.9 (3.5%), Баянхонгор – 41.5 (3.3%), үлдсэн 420.2 (31.6%) мянга нь бусад аймгуудад байна.

Өрхийн зарим нэг шинж байдлаар ажиллагчдыг үзэхэд 18[1] ба түүнээс дээш насны нийт ажиллагчдын 76.1 хувь нь гэрлэсэн, 15.4 хувь нь огт гэрлээгүй, 4.1 хувь нь бэлбэсэн хүмүүс байна. Энэ хандлага байршлын хувьд ижилхэн байсан ба харин хүйсийн хувьд ялгаатай байсан. Тухайлбал, эрэгтэй ажиллагчдын хувьд бэлбэсэн хүмүүсийн эзлэх хувь харьцангуй бага буюу 1.3 хувийг эзэлж байна.

**Хүснэгт 6.2. 18, түүнээс дээш насны ажиллагчдын гэрлэлтийн байдал, хүйс, байршлаар**

| Гэрлэлтийн байдал | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Хот | Хөдөө |
|---|---|---|---|---|---|
| Огт гэрлээгүй | 15.4 | 17.5 | 13.0 | 16.4 | 13.9 |
| Гэрлэсэн: | | | | | |
| - Батлуулсан | 68.6 | 70.2 | 66.8 | 65.0 | 74.0 |
| - Батлуулаагүй | 7.5 | 8.0 | 7.1 | 8.9 | 5.5 |
| Тусгаарласан | 2.4 | 1.8 | 3.0 | 3.1 | 1.2 |
| Цуцалсан | 2.0 | 1.2 | 2.9 | 2.6 | 1.1 |
| Бэлбэсэн | 4.1 | 1.3 | 7.2 | 4.0 | 4.3 |
| Дүн, % | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 18, түүнээс дээш насны ажиллагчид | 1 247 030 | 664 630 | 582 399 | 745 239 | 501 791 |
| 18, түүнээс дээш насны хүн ам | 2 078 799 | 977 690 | 1 101 109 | 1 392 595 | 686 204 |
| Гэрлэсэн хүн | 1 387 008 | 687 059 | 699 949 | 898 629 | 488 379 |

Тухайн үеийн ажиллагчдыг боловсролын түвшингээр нь харахад 3 хүн тутмын нэг нь дипломын дээд болон бакалаврын зэрэгтэй байна. Энэ хандлага эмэгтэй ажиллагчдын хувьд ижилхэн байсан бол харин эрэгтэй ажиллагчдын хувьд 3 хүн тутмын 1 нь техникийн болон мэргэжлийн боловсролтой байв.

[1] Манай улсын хувьд хуульд нийцүүлэн 18, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдлыг авч үздэг тухай өмнөх Бүлэг II-т дэлгэрэнгүй дурьдсан.

### Зураг 6.2. Ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр, дунд эзлэх хувиар




Ажиллагчдын боловсролын түвшинг хүйсээр ялган харуулахад, техникийн болон мэргэжлийн, боловсролгүй, бага болон суурь боловсролтой ажиллагчдын хувьд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа бол тусгай мэргэжлийн дунд, дипломын дээд болон бакалавр, магистр, доктор болон бүрэн дунд боловсролтой ажиллагчдын талаас илүү хувь нь эмэгтэйчүүд байна *(Зураг 6.3)*.

### Зураг 6.3. Ажиллагчдын боловсролын түвшин, хүйсээр



## 6.2 АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР

Тухайн үеийн ажиллагчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар гаргаж хавсралтад үзүүлэв. Ажиллагчдын хамгийн их буюу 26.7 хувь (334.1 мянга) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, хамгийн бага буюу 0.1 хувь нь үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт (770 хүн), мөн хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагааны (1.2 мянга) болон олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа (2.3 мянга)-ны салбаруудад тус тус хөдөлмөр эрхэлж байна.

Бусад салбараасаа илүү өндөр хувийг эзэлж байгаа 9 салбарын ажиллагчдыг хүйсээр ялган *Зураг 6.4*-т харууллаа.

**Зураг 6.4. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хүйсээр**




Хүйсээр салбарын ялгааг гарган харуулахад уул уурхай, барилга, олборлолт болон тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, барилга, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын ихэнх нь (51.0-84.0 хувь) эрэгтэйчүүд байхад бусад 12 салбарт ажиллагчид болон бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсрол

болон хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын талаас илүү хувь нь (56.6-81.8 хувь) эмэгтэйчүүд байна.

**Зураг 6.5. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, дүнд эзлэх хувиар**




Судалгаагаар нийт ажиллагчдын 583.4 (47.3%) мянга нь эмэгтэй ажиллагч бөгөөд 312.3 (53.5%) мянган эмэгтэй нь хөдөө аж ахуйн бус салбарт цалинтай хөдөлмөр эрхэлж байна.

ХАА-н бус салбарт цалинтай ажиллаж буй эмэгтэй ажиллагчдыг салбараар авч үзэхэд эмэгтэйчүүд хамгийн их ажиллаж байгаа нь боловсролын салбар буюу бараг 5 эмэгтэй тутмын 1 нь энэ салбарт ажиллаж байна.

### Зураг 6.6. ХАА-н бус салбарт цалин хөлстэй ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, салбараар




## 6.3 АЖИЛЛАГЧИД, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР

Тухайн үед хөдөлмөр эрхэлсэн хүн амын тоог ажил мэргэжлийн ангиллаар гаргаж *(Зураг 6.7)*-д харуулав. Тухайн үед хөдөлмөр эрхэлсэн хүн амын 327.9 (26.2%) мянга нь хөдөө, аж ахуй, ой, загас агнуурын ажил хийж байгаа нь нийт ажиллагчдын дунд хамгийн их хувийг эзэлж байна.

## Зураг 6.7. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар




Ажиллагчдын ажил мэргэжлийг хүйсээр ялган харахад суурин төхөөрөмж, машин, механизмын операторч, угсрагчаар ажиллагчдын хувьд эрэгтэйчүүд өндөр хувьтай байгаа бол контор, үйлчилгээний ажилтнаар ажиллагчдын дунд эмэгтэйчүүд илүү өндөр хувьтай байна.

## Зураг 6.8. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр



## 6.4 АЖИЛЛАГЧИД, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР

Ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар авч үзэхэд 2 хүн тутмын 1 нь нь цалин хөлстэй ажиллагч, бараг 5 хүн тутмын 1 нь мал аж ахуй эрхлэгч, болон хувиараа хөдөлмөр эрхлэгч гэсэн статуст хамаарч байна. Мөн энэ харьцаа хүйсийн хувьд хадгалагдаж байна.

**Зураг 6.9. Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар**




Ажил олгогч арван хүний ес нь, хувиараа хөдөлмөр эрхлэгч таван хүний гурав нь, мал аж ахуй эрхлэгч дөрвөн хүний нэг нь эрэгтэйчүүд байхад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч таван хүний бараг дөрөв нь эмэгтэйчүүд байна.

Харин нөхөрлөл, хоршооны гишүүдийн хувьд хүйсийн харьцаа тэнцвэртэй харагдаж байна (*Зураг 6.10*).

**Зураг 6.10. Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүйсээр**



## 6.5 АЖИЛЛАГЧИД, БАЙГУУЛЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭРЭЭР

Малчдаас бусад ажиллагчдын хувьд аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд хамгийн их нь буюу 383.7 (40.1%) мянга нь хувийн аж ахуйн нэгжид, хамгийн бага нь буюу 7.4 (0.8%) мянга нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт ажиллаж байна.

**Хүснэгт 6.3. Ажиллагчид, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэр, байршлаар**

| Хариуцлагын хэлбэр | Бүгд | | Байршил | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хот | | Хөдөө | |
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % |
| Төрийн өмчит үйлдвэрийн газар | 42 868 | 4.5 | 33 557 | 4.6 | 9 311 | 4.1 |
| Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар | 7 397 | 0.8 | 4 440 | 0.6 | 2 957 | 1.3 |
| Төсөвт байгууллага | 214 615 | 22.4 | 142 184 | 19.4 | 72 431 | 32.2 |
| Төрийн бус байгууллага | 19 861 | 2.1 | 14 721 | 2.0 | 5 140 | 2.3 |
| Хувийн аж ахуйн нэгж | 383 718 | 40.1 | 330 545 | 45.2 | 53 173 | 23.7 |
| Хувь хүн/ иргэн | 287 996 | 30.1 | 206 090 | 28.2 | 81 906 | 36.4 |
| Дүн, % | | 100.0 | | 100.0 | | 100.0 |
| Тоо* | 956 455 | | 731 537 | | 224 918 | |

**-Нийт 1 253.0 мянган ажиллагчид байгаагаас 296.6 мянга нь мал аж ахуй эрхлэгчид байна. Үлдсэн 956.5 мянган ажиллагчид дээрх аж ахуйн нэгж, байгууллагад харьяалагдаж байна.*

Хөдөө орон нутгийн ажиллагчдын 36.4 хувь нь хүн, иргэн хэлбэрээр, хот суурин газрын ажиллагчдын 45.2 хувь нь хувийн аж ахуйн нэгжид ажиллаж байна.

**Зураг 6.11. Ажиллагчид, байгууллагын хариуцлагын хэлбэр, бүсээр, дүнд эзлэх хувиар**



## 6.6 ДАВХАР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Үндсэн ажлын хажуугаар давхар хөдөлмөр эрхэлж буй хүн амын талаарх мэдээллийг энэхүү судалгаагаар судалсан. Давхар хөдөлмөр эрхэлж байгаа болон сүүлийн долоо хоногт давхар хөдөлмөр эрхлээгүй боловч тогтмол хийх давхар ажилтай нийт 22.6 мянган хүн байна. Сүүлийн 7 хоногт давхар хөдөлмөр эрхэлсэн иргэд хөдөлмөр эрхэлж буй нийт хүн амын 1.8 хувийг эзэлж байна. Эрхэлж буй үндсэн ажлын үргэлжлэх хугацаа /цаг/ урт, цаг агаарын хүнд нөхцөл, эдийн засгийн өнөөгийн бүтэц, эдийн засгийн хямрал зэргээс шалтгаалж, давхар хөдөлмөр эрхлэх боломжоо хязгаарлагдмал байж болзошгүй юм.

Давхар хөдөлмөр эрхлэгчдийн 3 хүн тутмын нэг хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан байгаа нь бусад мэргэлийн ажиллагчдаас хамгийн их хувийг эзэлж байна. Нийт хөдөлмөр эрхлэгчдийн дунд давхар хөдөлмөр эрхэлсэн хүн амын эзлэх хувь 2017 онтой харьцуулахад 0.1 пунктээр нэмэгдсэн дүнтэй байна. *(Хүснэгт 6.4).*

***Хүснэгт 6.4.* Давхар хөдөлмөр эрхэлсэн хүн ам, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр**

| Ажил мэргэжлийн ангилал | Бүгд | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % |
| Менежер | 1314 | 5.8 | 1035 | 7.1 | 279 | 3.5 |
| Мэргэжилтэн | 1116 | 4.9 | 337 | 2.3 | 778 | 9.6 |
| Техникч болон туслах дэд мэргэжилтэн | 237 | 1.1 | 119 | 0.8 | 118 | 1.5 |
| Контор, үйлчилгээний ажилтан | 253 | 1.1 | 107 | 0.7 | 146 | 1.8 |
| Худалдаа, үйлчилгээний ажилтан | 4879 | 21.6 | 2496 | 17.2 | 2383 | 29.5 |
| Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан | 7323 | 32.5 | 4976 | 34.4 | 2347 | 29.1 |
| Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан | 4355 | 19.3 | 2659 | 18.4 | 1695 | 21.0 |
| Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч | 1703 | 7.6 | 1704 | 11.8 | - | - |
| Энгийн ажил, мэргэжил | 1373 | 6.1 | 1045 | 7.2 | 329 | 4.1 |
| Дүн, % | | 100.0 | | 100.0 | | 100.0 |
| Улсын дүн | 22 553 | | 14 478 | | 8 075 | |

# БҮЛЭГ VII

# АЖИЛГҮЙДЭЛ






62

## 7.1. АЖИЛГҮЙ ИРГЭД

Судалгааны дүнгээр сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлэх боломжтой, ажил хайсан ажилгүй иргэд 105.6 мянга байгаагийн 60.9 буюу 57.7 хувь нь эрэгтэй, 44.7 буюу 42.3 хувь нь эмэгтэй байна. Ажилгүй иргэдийг бүс нутгаар авч үзвэл ажилгүй таван хүний хоёр нь Улаанбаатар хотод байна. Харин 15 ба түүнээс дээш насны нийт хүн амд эзлэх ажилгүй иргэдээр баруун бүс хамгийн өндөр хувийг эзэлж байна.

**Хүснэгт 7.1. 15, түүнээс дээш насны хүн амд ногдох ажилгүй иргэд, бүсээр**

| Бүс | 15, түүнээс дээш насны хүн ам | Ажилгүй иргэд | Хувь |
|---|---|---|---|
| Баруун | 267 829 | 17 231 | 6.4 |
| Хангай | 407 278 | 20 019 | 4.9 |
| Төв | 352 137 | 17 811 | 5.1 |
| Зүүн | 159 742 | 8 259 | 5.2 |
| Улаанбаатар | 1 039 610 | 42 294 | 4.1 |
| Бүгд | 2 226 596 | 105 614 | 4.7 |

Нийт ажилгүй иргэдийн 42.3 мянга буюу 40.0 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байгаа боловч 15 ба түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь нь 4.1 хувь байна. Харин Улаанбаатар хотын хувьд ажилгүй иргэдийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс 29.6 (эрэгтэйчүүд 64.8 хувь, эмэгтэйчүүд 35.2 хувь) пунктээр өндөр байна. Бүс нутгийн хувьд зөвхөн Баруун бүсэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 7.7 пунктээр өндөр байгаа бол бусад бүс нутагт эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс 29.7 пунктээр өндөр байна. Өөрөөр хэлбэл эрэгтэйчүүд ажилгүйдэлд илүү их өртөж байгаа нь харагдаж байна.

*Зураг 7.1*-т харуулснаар нийт ажилгүй иргэдийн 56.1 хувийг 15-34 насны залуус, 31.0 хувийг 35-49 насныхан эзэлж байна. Ажилгүй иргэд нас ахих тусам буурч, 50-54 насанд 9.0 хувь буюу 9.5 мянга болсон байна. Эндээс харахад залуу хүмүүс, ялангуяа ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орж буй хүмүүс ажилгүйдэлд илүүтэй өртөж байна. Ажилгүй иргэдийг хүйсээр авч үзэхэд 20-49 насны бүлэгт эмэгтэйчүүдийн эзлэх хувь тухайн насны эрэгтэйчүүдийнхээс 0.6-4.0 пунктээр илүү байна. Хүйсийн хувьд хамгийн их ялгаатай байгаа нь 55-аас дээш насны бүлэг байгаа ба эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эмэгтэйчүүдийнхээс 3.3 мянга буюу 89.2 хувиар илүү байна.

**Зураг 7.1. Ажилгүй иргэдийн насны бүтэц, хүйсээр, хувиар**




## 7.2 АЖИЛГҮЙДЛИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

Энэхүү судалгаагаар ажилгүйдлийн үргэлжлэх хугацааны талаарх мэдээллийг цуглуулсан бөгөөд ажилгүй иргэдийг ажил хийх боломжтой байсан хугацаагаар, хүйсээр харахад 2018 оны байдлаар ажил хийх боломжтой байсан хугацаа өсөх тусам ажилгүй иргэдийн хувь өсч нийт ажилгүй иргэдийн 65.3 мянга буюу 61.8 хувь нь 12 ба түүнээс дээш сараар ажил хийх боломжтой, ажилгүй иргэд байсан байна.

**Зураг 7.2. Ажилгүй иргэд, ажил хийх боломжтой байсан хугацаагаар, хувиар**




## 7.3. АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Судалгааны дүнгээр нийт ажилгүй иргэдийн арван хүн тутмын гурав нь техникийн болон мэргэжлийн, мөн гурав нь дипломын дээд болон бакалаврын боловсролтой, бараг хоёр нь бүрэн дунд боловсролтой иргэд байна. Гэтэл ажилгүй

иргэдийн дунд боловсролгүй болон бага боловсролтой иргэдийн эзлэх хувь нилээд бага буюу 4.7 хувь байна.

**Хүснэгт 7.2. Ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, хүйсээр, дунд эзлэх хувиар**

| Боловсролын түвшин | Бүгд | Хүйсээр | |
|---|---|---|---|
| | | Эрэгтэй | Эмэгтэй |
| Боловсролгүй | 1.7 | 1.7 | 1.8 |
| Бага | 3.0 | 2.9 | 3.0 |
| Суурь | 8.4 | 9.6 | 6.8 |
| Бүрэн дунд | 18.1 | 18.7 | 17.3 |
| Техникийн болон мэргэжлийн | 29.7 | 34.8 | 22.7 |
| Тусгай мэргэжлийн дунд | 4.8 | 4.7 | 5.0 |
| Дипломын дээд болон бакалавр | 33.2 | 27.2 | 41.4 |
| Магистр ба түүнээс дээш | 1.1 | 0.4 | 2.0 |
| Дүн, % | 100.0 | 100.0 | 100.0 |
| Тоо | 105 614 | 60 948 | 44 666 |

## 7.4. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН

Ажилгүйдлийн түвшин нь хөдөлмөрийн зах зээлийн хамгийн түгээмэл хэрэглэгддэг үзүүлэлт бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэргүй байгааг, ашиглаж чадахгүй байгаа хөдөлмөрийн нийлүүлэлтийн хэмжээг илэрхийлдэг. Судалгааны дүнгээр ажил эрхлээгүй нийт хүн амаар тооцсон ажилгүйдлийн улсын дундаж түвшин 7.8 хувь байна. Хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 8.3 хувь, эмэгтэйчүүдийнх 7.1 хувьтай байна. Хот, суурин газрын хүн амын ажилгүйдлийн түвшин 9.4 хувь буюу улсын дунджаас 1.6 пунктээр дээгүүр, харин хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин бага буюу 5.2 хувь болж, улсын дунджаас 2.6 пунктээр доогуур байна. 2017 оныхтой харьцуулахад эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 1.3 пунктээр, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 0.7 пунктээр буурсан байна.

Ажилгүйдлийн түвшин Баруун бүсэд 8.9 хувь, Зүүн бүсэд 8.7 хувь буюу улсын дундажаас 0.9-1.1 пунктээр дээгүүр байгаа бол Төвийн бүс болон Улаанбаатар хотод 7.6 хувь, Хангайн бүсэд 7.1 хувь буюу улсын дунджаас 0.2-0.7 пунктээр доогуур байна.

Ажилгүйдлийн түвшинг насны бүлгээр авч үзвэл 15-19 (24.5 хувь), 20-24 (19.4 хувь), 25-29 (10.8 хувь) насны залуучуудын ажилгүйдлийн түвшин улсын дунджаас 3.0-16.7 пунктээр дээгүүр байна. Ажил эрхлээгүй 15-29 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин бусад насны бүлгийн ажилгүй иргэдийн түвшингээс өндөр байгаа нь дараах зургаас *(Зураг 7.3)* харагдаж байна.

**Зураг 7.3. Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр**




Ажилгүйдлийн түвшинг насны бүлэг, хүйсээр нь авч үзэхэд 15-29 насны бүлэгт эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа бол бусад насны бүлэгт эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс доогуур байна.

Ажилгүйдлийн түвшин Дархан-Уул, Орхон, Баян-Өлгий, Говьсүмбэр, Хэнтий, Увс, Сүхбаатар, Ховд аймагт улсын дунджаас 0.6-11.8 пунктээр дээгүүр, харин бусад аймаг болон Улаанбаатар хотод 0.2-5.2 пунктээр доогуур байна.

Боловсролгүй, бага болон магистр ба түүнээс дээш боловсролтой эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин тухайн боловсролын түвшинтэй эрэгтэйчүүдийнхээс 1.2-3.2 пунктээр өндөр байхад бусад боловсролын түвшинтэй эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин тухайн боловсролын түвшинтэй эмэгтэйчүүдийнхээс 0.1-3.9 пунктээр өндөр байна.

### Зураг 7.4. Ажилгүйдлийн түвшин, аймаг, нийслэлээр




### Зураг 7.5. Ажилгүйдлийн түвшин, боловсролын түвшин, хүйсээр




Ажилгүйдлийн түвшнийг гэрлэлтийн байдлаар авч үзвэл огт гэрлээгүй хүмүүсийн ажилгүйдлийн түвшин өндөр байна. Гэрлэлтийн байдлаарх ажилгүйдлийн түвшинг хүйсээр авч үзэхэд огт гэрлэж байгаагүй эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин мөн түвшний эрэгтэйчүүдийнхаас 2.1 пунктээр их байгаа бол бусад гэрлэлтийн түвшинд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс 0.4-6.3 пунктээр их байна. Нийт

ажиллагчдийн 104.2 мянга буюу 8.3 хувь нь 18-аас дээш насны ажилгүй иргэд байна. Гэрлэлтийн байдлаар авч үзвэл 53.6 мянга буюу 8.3 хувь нь гэрлэсэн байна.

**Зураг 7.6. Ажилгүйдлийн түвшин, гэрлэлтийн байдлаар**




## 7.5 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН

Ажилгүй иргэдийг ажилгүй байгаа шалтгаанаар нь авч үзвэл 51.2 мянга (48.5%) нь ажил хайгаад олдохгүй байгаа, 13.6 мянга (12.9%) нь мэргэжилд тохирох ажил олдохгүй, 10.0 мянга (9.4%) нь мэргэжил, дадлага, туршлага байхгүй, 4.6 мянга (4.4%) нь тухайн жилд сургууль төгссөн, 4.1 мянга (3.9%) нь улиралын чанартай ажил хийдэг болохоор, 3.9 мянга (3.7%) нь ажил олгогчийн тавьсан шаардлагад тэнцэхгүй байгаа учраас, 3.7 мянга (3.5%) нь цомхотголд орсон учраас хөдөлмөр эрхлээгүй гэсэн хариулт өгчээ *(Зураг 7.7).*

**Зураг 7.7. Ажилгүй иргэд, хөдөлмөр эрхлээгүй шалтгаанаар, хувиар**



Дээрх зурагт хөдөлмөр эрхлээгүй 8 төрлийн шалтгааныг оруулсан хэдий ч судалгаагаар ажилгүй иргэдээс ажилгүй байгаа 25 төрлийн шалтгааныг тодруулж асуусан юм, бусад шалтгаанаар ажилгүй байгаа иргэдийн эзлэх хувь бага байна. Ажилгүй иргэдийн ихэнх нь буюу хоёр хүний нэг нь ажил хайгаад олдохгүй байгаа гэж хариулсан байна. Мөн арван хүн тутмын нэг нь мэргэжил, дадлага туршлага байхгүй гэж хариулсан нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг хангасан эрэлт, хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх нь чухал байгааг харуулж байна.

Ажил хайгаад олдохгүй байгаа ажилгүй иргэдийг эзэмшсэн ажил мэргэжлээр авч үзвэл дийлэнх нь буюу 30.1 хувь нь энгийн ажил, мэргэжилтэй, 24.6 хувь нь мэргэжилтэн, 16.2 хувь нь машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, 13.4 үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажил, 8.8 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, үлдсэн нь бусад мэргэжилтэй хүмүүс байна.

**Зураг 7.8. Ажил хайгаад олдохгүй байгаа ажилгүй иргэд, эзэмшсэн ажил мэргэжлээр, хувиар**




Мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа ажилгүй иргэдийг эзэмшсэн ажил мэргэжлээр нь авч үзвэл бараг хоёр хүн тутмын нэг нь буюу 64.9 хувь нь мэргэжилтэн, 11.4 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил, 7.9 хувь нь машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, 6.3 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 4.0 хувь нь техникч болон туслах/ дэд мэргэжилтэй байна *(Зураг 7.9)*.

**Зураг 7.9. Мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа ажилгүй иргэд, эзэмшсэн ажил мэргэжлээр, хувиар**



# БҮЛЭГ VIII
# ЗАЛУУЧУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ

**ЗАЛУУ АЖИЛЛАГЧИД, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар**



## 8.1 ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Судалгааны дүнгээр 15-аас 24 насны 434.0 мянган хүн байгаагийн 219.1 мянга буюу 50.5 хувь нь эрэгтэй, 214.9 мянга буюу 49.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Эдгээр залуучуудын 131.0 мянга буюу 30.2 хувь нь эдийн засгийн идэвхтэй, 303.0 мянга буюу 69.8 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн ам байна. Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн амын 104.3 мянга буюу 79.6 хувь нь ажиллагчид, харин 26.7 мянга буюу 20.4 хувь нь ажилгүй иргэд байна.

Хүснэгт 8.1. Залуу ажиллагчид, байршил, бүс, хүйсээр

| Байршил/ Бүс | Бүгд | | Хүйсээр | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % |
| Хот | 55 401 | 53.1 | 32 814 | 50.1 | 22 587 | 58.2 |
| Хөдөө | 48 918 | 46.9 | 32 700 | 49.9 | 16 218 | 41.8 |
| | | | | | | |
| Баруун | 14 329 | 13.7 | 9 749 | 14.9 | 4 580 | 11.8 |
| Хангайн | 24 380 | 23.4 | 16 042 | 24.5 | 8 338 | 21.5 |
| Төвийн | 16 843 | 16.2 | 10 364 | 15.8 | 6 479 | 16.7 |
| Зүүн | 6 694 | 6.4 | 4 762 | 7.3 | 1 932 | 5.0 |
| Улаанбаатар | 42 073 | 40.3 | 24 597 | 37.5 | 17 476 | 45.0 |
| Дүн, % | | 100.0 | | 100.0 | | 100.0 |
| Улсын дүн | 104 319 | | 65 514 | | 38 805 | |

Нийт хөдөлмөр эрхлэгчдийн 104.3 мянга нь буюу 8.3 хувь нь 15-24 насны залуучууд байна. Үүнээс хүйсийн хувьд 62.8 хувь эрэгтэйчүүд, 37.2 хувь эмэгтэйчүүд байна.

Харин залуу ажиллагчдын 53.1 хувь нь хотод, 46.9 хувь нь хөдөөд ногдож байна. Бүсийн хувьд Улаанбаатар хотыг оруулахгүйгээр Хангай, Төв болон Баруун бүсэд залуучуудын хөдөлмөр эрхлэлт өндөр, Зүүн бүсэд харьцангүй бага байна.

Аймгуудын хувьд харьцуулан харахад хялбар байх үүднээс Улаанбаатар хотыг оруулахгүйгээр залуучуудын хөдөлмөр эрхлэлт өндөр болон бага байгаа байдлыг бүсийн ялгаатай байдлаар Зураг 8.1-т харуулав.

### Зураг 8.1. Залуу ажиллагчид, аймаг, хүйсээр




Залуучуудын хөдөлмөр эрхлэлт өндөр байгаа бүсүүдийг аймгуудаар задлан харахад Хангайн бүсээс Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор аймгуудад, Баруун бүсээс Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад, Төвийн бүсээс Сэлэнгэ, Төв, Дорноговь аймгуудад залуучуудын хөдөлмөр эрхлэлт тухайн бүсийнхээ бусад аймгуудаас өндөр байна.

Улсын хэмжээнд нийт ажиллагчдын 8.3 хувийг 15-24 насныхан эзэлж байгаа ба аймгийн түвшинд авч үзэхэд Хэнтий, Сэлэнгэ, Увс, Дорноговь, Дундговь, Хөвсгөл аймгуудад 0.3-1.2 пунктээр, Баян-Өлгий аймагт 1.8 пунктээр, Архангай аймагт 2.7 пунктээр, Өвөрхангай аймагт 2.9 пунктээр, Баянхонгор аймагт 4.1 пунктээр улсын дунджаас дээгүүр байна (Зураг 8.2).

## Зураг 8.2. Залуу ажиллагчид, аймгаар, нийт ажиллагчдад эзлэх хувиар




## Хүснэгт 8.2. Залуу ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр

| Боловсролын түвшин | Бүгд | | Хүйсээр | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % |
| Болосролгүй | 3 005 | 2.9 | 2 383 | 3.6 | 622 | 1.6 |
| Бага | 2 968 | 2.8 | 2 257 | 3.4 | 711 | 1.8 |
| Суурь | 14 195 | 13.6 | 11 380 | 17.4 | 2 815 | 7.3 |
| Бүрэн дунд | 23 762 | 22.8 | 16 131 | 24.6 | 7 631 | 19.7 |
| Техникийн болон мэргэжлийн | 23 849 | 22.9 | 17 159 | 26.3 | 6 690 | 17.2 |
| Тусгай мэргэжлийн дунд | 3 981 | 3.8 | 2 305 | 3.5 | 1 676 | 4.3 |
| Дипломын болон бакалаврын дээд | 31 910 | 30.5 | 13 752 | 21.0 | 18 158 | 46.8 |
| Магистр ба түүнээс дээш | 649 | 0.6 | 147 | 0.2 | 502 | 1.3 |
| Дүн, % | | 100.0 | | 100.0 | | 100.0 |
| Улсын дүн | 104319 | | 65514 | | 38805 | |

Залуу ажиллагчдын хувьд арван хүн тутмын гурав нь дипломын болон бакалаврын дээд, таван хүн тутмын нэг нь техникийн болон мэргэжлийн мөн нэг нь бүрэн дунд боловсролтой залуучууд байгааг Хүснэгт 8.2-д харуулав. Харин залуу ажиллагчдын 2.9 хувь нь боловсролгүй байна.

Хүйсийн хувьд харахад, эрэгтэй залуу ажиллагчдын хамгийн өндөр хувийг буюу 26.3 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой байгаа байна. Харин 3.6 хувь нь боловсролгүй байна. Эмэгтэй залуу ажиллагчдын хувьд хамгийн өндөр болох 46.8 хувь нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой байгаа бол хамгийн бага

буюу 1.3 хувь нь магистр ба түүнээс дээш зэрэгтэй, харин 1.6 хувь нь боловсролгүй байна. Эндээс эмэгтэй залуу ажиллагчид илүү боловсрол өндөртэй байгаа нь харагдаж байна.

**Зураг 8.3. Залуу ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр**




Залуу ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харахад нийт 5 ангилалд хуваагдан ажиллаж байгааг Зураг 8.4-өөс харж болно. Залуу ажиллагчдын 56.4 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 32.0 хувь нь мал аж ахуй эрхлэгч, 6.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч гэсэн статуст хамаарч байна.

**Зураг 8.4. Залуу ажиллагчдын, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар**



Залуучуудын боловсролын түвшингээр хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харьцуулан харахад зарим нэг сонирхолтой статистик харагдаж байгааг *Зураг 8.5-аас* харж болно. Магистр ба түүнээс дээш зэрэгтэй залуус бүгд цалин хөлстэй ажиллагч байна. Цалин хөлстэй ажиллагчдын хувьд тодорхой мэргэжил эзэмших түвшний боловсролын түвшинтэй байхад малчдын хувьд бүрэн дунд болон түүнээс доош боловсролын түвшинтэй байна.

## Зураг 8.5. Залуу ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар



| | Боловсрол гүй | Бага | Суурь | Бүрэн дунд | Техникийн болон мэргэжлийн | Тусгай мэргэжлийн дунд | Диплом-ын дээд болон бакалавр | Магистр ба түүнээс дээш |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цалин хөлстэй ажиллагч | 5.9 | 13.1 | 17.3 | 44.6 | 62.2 | 75.5 | 84.0 | 100.0 |
| Нөхөрлөл, хоршооны гишүүн | 0.0 | 0.0 | 0.0 | 0.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 2.9 | 2.6 | 3.1 | 5.2 | 11.1 | 2.5 | 7.8 | 0.0 |
| Мал аж ахуй эрхлэгч | 87.2 | 79.9 | 73.9 | 43.2 | 23.7 | 17.5 | 4.2 | 0.0 |
| Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч | 4.0 | 4.4 | 5.7 | 6.7 | 3.0 | 4.5 | 4.0 | 0.0 |

Хөдөлмөр эрхэлсэн залуу ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллаар гаргаж харуулав *(Зураг 8.6)*. Залуу ажиллагчдын 36.2 мянга буюу 34.7 хувь нь хөдөө, аж ахуй, ой, загас агнуурын ажил хийж байгаа нь нийт залуу ажиллагчдын дүнд хамгийн их хувийг, худалдаа, үйлчилгээний ажилтан 17.1 хувийг, мэргэжилтэн 16.0 хувийг, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан 9.4 хувийг, энгийн ажил, мэргэжил 8.8 хувийг, суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч 4.7 хувийг эзэлж байна.

Залуу ажиллагчдын хамгийн их буюу 35.4 хувь (36.9 мянга) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт байхад олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт 0.1 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Тухайн үед хөдөлмөр эрхэлсэн залуучуудын /12.8 мянга буюу 12.3 хувь/ нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, боловсруулах үйлдвэрлэл /8.8 мянга буюу 8.4 хувь/, /8.2 мянга буюу 7.8 хувь/ нь барилгын салбарын ажиллагчид, Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны

үйлчилгээ /6.2 мянга буюу 6.0 хувь/, Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал /5.6 мянга буюу 5.4 хувь/, Уул уурхай, олборлолт /4.7 мянга буюу 4.5 хувь/, зэрэг салбарын залуу ажиллагчдын хувийн жин бусад салбарынхтай харьцуулахад харьцангуй өндөр байна.

## Зураг 8.6. Залуу ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар




## Зураг 8.7. Залуу ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар, хүйсээр



## 8.2 ЗАЛУУЧУУДЫН АЖИЛГҮЙДЭЛ

Нийт ажилгүй иргэдийн 26.7 мянга буюу 25.3 хувь нь 15-24 насны залуучууд байна. Энэ насны ажилгүй эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүд эзлэх хувиас 13.9 пунктээр доогуур байна.

Хүснэгт 8.3. 15-24 насны ажилгүй иргэд, нийт ажилгүй иргэдэд эзлэх хувь, ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр

| Насны бүлэг | Ажилгүй иргэд | | | | | | Ажилгүйдлийн түвшин | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | | Хүйсээр | | | | Бүгд | Хүйсээр | |
| | | | Эрэгтэй | | Эмэгтэй | | | Эрэгтэй | Эмэгтэй |
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % | | | |
| 15-19 | 6 062 | 5.7 | 4 323 | 7.1 | 1 739 | 3.9 | 24.5 | 23.2 | 28.5 |
| 20-24 | 20 612 | 19.5 | 10 871 | 17.8 | 9 741 | 21.8 | 19.4 | 17.5 | 22.0 |
| 15-24 | 26 674 | 25.3 | 15 194 | 24.9 | 11 480 | 25.7 | 20.4 | 18.8 | 22.8 |
| Нийт | 105 614 | | 60 948 | | 44 666 | | 7.8 | 8.3 | 7.1 |

Судалгааны дүнгээр нийт 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 20.4 хувь буюу улсын дунджаас 2.6 дахин их байна (улсын дундаж 7.8 хувь). Энэ насны эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин нь 18.8 хувь, эмэгтэйчүүдийнх 22.8 хувь байгаа нь хүйсээр тооцсон ажилгүйдлийн улсын дунджаас тус бүр 1.3-2.2 дахин өндөр байна.

15-24 насны ажилгүй иргэдийг байршлаар авч үзвэл нийт ажилгүй иргэдэд энэ насны ажилгүй иргэдийн эзлэх хувь нь хөдөөд хот суурин газрынхаас 2.4 пунктээр өндөр байна. 15-24 насны ажилгүй иргэдийн ажилгүйдлийн түвшинг байршлаар авч үзвэл хотынхны ажилгүйдлийн түвшин нь тухайн насны бүлэг дэх улсын дунджаас 17.9 пунктээр, хөдөөд 5.6 пунктээр өндөр байна.

**Хүснэгт 8.4. 15-24 насны ажилгүй иргэд, нийт ажилгүй иргэдэд эзлэх хувь, ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, байршлаар**

| Насны бүлэг | Ажилгүй иргэд | | | | | | Ажилгүйдлийн түвшин | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | | Байршлаар | | | | Бүгд | Байршлаар | |
| | | | Хот | | Хөдөө | | | Хот | Хөдөө |
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % | | | |
| 15-19 | 6 062 | 5.7 | 4 204 | 5.4 | 1 858 | 6.7 | 25.7 | 37.8 | 13.6 |
| 20-24 | 20 612 | 19.5 | 14 929 | 19.2 | 5 683 | 20.3 | 13.4 | 23.5 | 13.3 |
| 15-24 | 26 674 | 25.3 | 19 133 | 24.6 | 7 541 | 27.0 | 20.4 | 25.7 | 13.4 |
| Нийт | 105 614 | | 77 686 | | 27 928 | | 7.8 | 9.4 | 5.2 |

15-24 насны ажилгүй иргэдийг ажилгүй байгаа шалтгаанаар нь авч үзвэл 39.7 хувь нь ажил хайгаад олдохгүй байгаа, 17.2 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа, 16.2 хувь нь тухайн жилд сургууль төгссөн, 12.0 хувь нь мэргэжил, дадлага

туршлага байхгүй, 3.1 хувь нь ажил олгогчийн тавьсан шаардлагад тэнцэхгүй байгаа, 11.8 хувь нь бусад шалтгаанаар ажил эрхлээгүй гэсэн хариулт өгчээ.

**Зураг 8.8. 15-24 насны ажилгүй иргэд, хөдөлмөр эрхлээгүй шалтгаанаар, хувиар**



# БҮЛЭГ IX

# АЛБАН БУС САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



82

## 9.1 АЛБАН БУС САЛБАРТ АЖИЛЛАГЧИД

Хөгжиж буй орнуудад хөдөө аж ахуйн салбар дахь албан бус салбарын үйл ажиллагааг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг тул ОУХБ нь хөдөө аж ахуйн (ХАА) салбарыг албан бус салбарын хүрээнээс гаргаж, зөвхөн ХАА-н бус чиглэлийн үйл ажиллагаag тус салбарт хамруулан тооцохоор тогтсон. Монгол Улсын нийт ажиллагчдын 26.7 хувийг шингээсэн ХАА-н салбар нь эдийн засгийн хамгийн том салбаруудын нэг бөгөөд ХАА-н салбар дахь үйл ажиллагаанд өрхийн жижиг аж ахуйн хэлбэр зонхилдог тул тус салбарыг албан бус салбарт хамруулан тооцдоггүй. ХАА-н бус салбарт ажиллагчид 918.9 мянга (73.3%) байгаагийн таван хүн тутмын дөрөв нь хот, суурин газарт, харин нэг нь хөдөө орон нутагт ажиллаж байна. ХАА-н бус салбарт ажиллагчдын 54.8 хувь нь Улаанбаатар хотод байгаа нь албан бус хөдөлмөр эрхлэгчид нийслэл хотод дийлэнх нь байгааг харуулж байна.

Судалгааны дүнгээр 2018 онд улсын хэмжээнд албан бус салбарт ажиллагчид 220.0 мянга байгаагийн 131.7 (59.9%) мянга нь эрэгтэй, 88.3 (40.1%) мянга нь эмэгтэй байна. Албан бус салбарт орлогыг нь тодорхойлох боломжгүй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэгч гэж авч үзэж байгаа ба 96.7 хувь нь үндсэн буюу анхдагч үйл ажиллагаагаараа, 3.3 хувь нь давхар буюу хоёрдогч үйл ажиллагаагаараа хувиараа хөдөлмөр эрхэлсэн байна.

**Хүснэгт 9.1. Албан бус салбарт ажиллагчид, хүйс, байршил, бүсээр**

| Хүйс | Бүгд | Байршлаар | | Бүсээр | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хот | Хөдөө | Баруун | Хангайн | Төвийн | Зүүн | Улаанбаатар |
| Бүгд | 219 996 | 165 152 | 54 844 | 29 628 | 31 284 | 40 136 | 12 183 | 106 765 |
| Үндсэн | 212 672 | 163 439 | 49 233 | 26 717 | 29 900 | 38 453 | 11 174 | 106 428 |
| Давхар | 7 324 | 1 713 | 5 611 | 2 911 | 1 384 | 1 683 | 1 009 | 337 |
| Эрэгтэй | 131 687 | 99 065 | 32 622 | 19 292 | 18 705 | 21 338 | 7 413 | 64 939 |
| Үндсэн | 126 874 | 97 938 | 28 936 | 17 462 | 17 735 | 20 319 | 6 680 | 64 678 |
| Давхар | 4 813 | 1 127 | 3 686 | 1 830 | 970 | 1 019 | 733 | 261 |
| Эмэгтэй | 88 309 | 66 087 | 22 222 | 10 336 | 12 579 | 18 798 | 4 770 | 41 826 |
| Үндсэн | 85 798 | 65 501 | 20 297 | 9 255 | 12 165 | 18 134 | 4 494 | 41 750 |
| Давхар | 2 511 | 586 | 1 925 | 1 081 | 414 | 664 | 276 | 76 |

*Зураг 9.1*-ээс харахад албан бус салбарт ажиллагчдын 75.1 хувь нь хот, суурин газарт, 24.9 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Харин албан бус салбар хөдөлмөр эрхлэгчдийг бүсээр авч үзэхэд 48.5 хувь нь Улаанбаатар хотод, 18.3 хувь нь Төвийн бүсэд, 14.2 хувь нь Хангайн бүсэд, 13.5 хувь нь Баруун бүсэд, 5.5 хувь нь Зүүн бүсэд байна.

**Зураг 9.1. Албан бус салбарт ажиллагчид, байршил, бүсээр, хувиар**




Албан бус салбарт ажиллагчдыг аймгаар нь авч үзвэл Баян-Өлгий, Өвөрхангай, Төв аймагт 4.1-4.9 хувь, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт 3.1-3.4 хувь, Ховд, Дорноговь, Орхон, Баянхонгор, Увс, Дундговь, Сүхбаатар, Хөвсгөл аймагт 2.2-2.9 хувь, Өмнөговь, Завхан, Дорнод, Архангай, Хэнтий, Говь-Алтай аймагт 1.3-1.9 хувь, Булган, Говьсүмбэр аймагт 0.5-0.6 хувь нь ажиллаж байна.

Үндсэн ажлаараа албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийг аймгаар авч үзэхэд Баян-Өлгий болон Өвөрхангай аймагт хамгийн их буюу тус бүр 4.3 хувийг, давхар ажлаараа албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн хувьд Баян-Өлгий аймагт 23.2 хувийг эзэлж байна. Харин Говьсүмбэр аймгийн хувьд хамгийн бага буюу нийт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 1.1 (0.5%) мянга нь албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байна.

## 9.2 АЛБАН БУС САЛБАРТ АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР

Албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг үндсэн салбараар авч үзэхэд худалдааны салбарт 43.5 хувь, үйлчилгээний салбарт 32.4 хувь, үйлдвэрлэлийн салбарт 24.1 хувь нь ажиллаж байна.

**Хүснэгт 9.2. Албан бус салбарт ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар**

| Салбар | Бүс | | | | | Бүгд |
|---|---|---|---|---|---|---|
| | Баруун | Хангайн | Төвийн | Зүүн | Улаанбаатар | |
| Үйлдвэрлэл | 9 394 | 7 908 | 9 638 | 3 398 | 22 660 | 52 998 |
| Худалдаа | 12 054 | 14 102 | 17 078 | 4 510 | 47 859 | 95 603 |
| Үйлчилгээ | 8 180 | 9 274 | 13 420 | 4 275 | 36 246 | 71 395 |
| Бүгд | 29 628 | 31 284 | 40 136 | 12 183 | 106 765 | 219 996 |

Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн таван хүн тутмын хоёр нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, нэг нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт, мөн нэг нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа нь эдгээр 3 салбарт ажиллагчид хамгийн ихээр ажиллаж байгааг харуулж байна. Энэ хандлага мөн хүйсээр хадгалагдаж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн хамгийн өндөр буюу 35.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажилласан бол эмэгтэйчүүдийн хувьд хамгийн өндөр буюу 55.3 хувь нь мөн уг салбарт ажилласан байна.

**Зураг 9.2. Албан бус салбарт ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хувиар**




## 9.3 АЛБАН БУС САЛБАРТ АЖИЛЛАГЧИД, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР

Албан бус салбарт хөдөлмөр эрхэлсэн нийт ажиллагчдын хамгийн их нь буюу 97.3 мянга /44.3 хувь/ нь худалдаа, үйлчилгээний ажил эрхэлсэн бөгөөд энэ ажил, мэргэжлээр эмэгтэйчүүдийн дийлэнх буюу 59.8 мянга /67.7 хувь/, эрэгтэйчүүдийн 37.6 мянга /28.5 хувь/ нь ажилласан байна. Үүнээс харахад өмнөх дэд бүлэгт нийт албан бус хөдөлмөр эрхлэгчид эдийн засгийн салбарын хувьд бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт хамгийн ихээр ажилласантай уялдаж байна.

Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн 55.2 (25.1%) мянга нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан эзэлж байгаагийн 34.6 (26.3%) мянга нь эрэгтэйчүүд байна. Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагчаар 44.5 мянган хүн ажилласан нь албан бус салбарт ажиллагчдын 20.2 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ мэргэжлээр эрэгтэйчүүдийн 42.3 (32.1%) мянга нь ажилласан байна.

**Хүснэгт 9.3. Албан бус салбар дахь ажиллагчид, ажил мэргэжлийн ангиллаар, хүйсээр**

| Ажил мэргэжлийн ангилал | Бүгд | | Хүйсээр | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % |
| Менежер | 4 781 | 2.2 | 3 368 | 2.5 | 1 413 | 1.6 |
| Мэргэжилтэн | 6 461 | 2.9 | 4 564 | 3.5 | 1 897 | 2.1 |
| Техникч болон туслах, дэд мэргэжилтэн | 2 718 | 1.2 | 1 918 | 1.5 | 800 | 0.9 |
| Контор, үйлчилгээний ажилтан | 504 | 0.2 | 271 | 0.2 | 233 | 0.3 |
| Худалдаа, үйлчилгээний ажилтан | 97 338 | 44.3 | 37 572 | 28.5 | 59 766 | 67.7 |
| Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан | 880 | 0.4 | 631 | 0.5 | 249 | 0.3 |
| Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил | 55 175 | 25.1 | 34 619 | 26.3 | 20 556 | 23.3 |
| Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч | 44 471 | 20.2 | 42 263 | 32.1 | 2 208 | 2.5 |
| Энгийн ажил, мэргэжил | 7 668 | 3.5 | 6 481 | 4.9 | 1 187 | 1.3 |
| Бүгд % | | 100.0 | | 100.0 | | 100.0 |
| Бүгд Тоо | 219 996 | | 131 687 | | 88 309 | |

Үндсэн хөдөлмөр эрхлэлтээрээ албан бус салбарт хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын тухайн үйл ажиллагаандаа хэр сэтгэл ханамжтай байдгийг дараах зургаар харууллаа.

**Зураг 9.3. Албан бус салбарт ажиллагчдын сэтгэл ханамжийн байдал**




Зурагт үзүүлснээр албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь буюу 83.0% нь өөрийн эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжтай (сэтгэл ханамжтай + сэтгэл ханамж өндөр) байдаг байна.

# БҮЛЭГ X
# АЖЛЫН ЦАГ БОЛОН ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

**Ажиллагчдын долоо хоногт зарцуулдаг байнгын ажлын цаг, хувиар**



88

## 10.1 АЖЛЫН ЦАГ

Монгол Улсын нийт ажиллагчдын бүх ажилдаа (үндсэн болон давхар ажилдаа) зарцуулдаг долоо хоногийн байнгын цагийг Ажиллах хүчний судалгааны мэдээллийг ашиглан сүүлийн 9 жилээр тооцлоо.

**Зураг 10.1. Ажиллагчдын бүх ажилдаа зарцуулдаг долоо хоногийн байнгын ажлын цагийн дундаж, хүйсээр**




Ажиллагчдын үндсэн болон давхар бүх ажилдаа зарцуулдаг долоо хоногийн байнгын ажлын цагийг дараах зургаас харахад 2010-2018 онуудад ихэнх нь (43.3-47.8%) долоо хоногт 40-48 цагаар ажилладаг нь харагдаж байна. 2018 онд ажиллагчдын бүх ажилдаа долоо хоногт зарцуулдаг байнгын ажлын цагийг авч үзэхэд, таван хүн тутмын хоёр нь 40-48 цагаар, нэг нь 49-59 цагаар ажиллаж байна. Мөн 60-аас дээш буюу урт цагаар ажиллаж байгаа ажиллагчид их байгаа (27.9%) бол 25-аас цөөн цаг ажиллаж байгаа ажиллагчид (2.8%) харьцангуй бага байдаг.

**Зураг 10.2. Ажиллагчид, бүх ажилдаа зарцуулдаг долоо хоногийн байнгын ажлын цагаар, хувиар**



Ажлын долоо хоногийн байнгын цагтаа богино цагаар (долоо хоногт 25-аас бага цаг) ажилладаг ажиллагчдыг байршлын хувьд авч үзэхэд хөдөөд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд хөдөө аж ахуйн салбарт, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар мал аж ахуй эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид дийлэнх нь байна. Харин урт цагаар (долоо хоногт 60-аас бага цаг) ажилладаг ажиллагчдыг байршлын хувьд авч үзэхэд хотод, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд үйлчилгээний салбарт, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар цалин хөлстэй ажиллагчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид дийлэнх нь байна.

**Хүснэгт 10.1. Долоо хоногт зарцуулдаг байнгын ажлын цаг нь богино болон урт байдаг ажиллагчид, хувиар**

| | Нийт ажиллагчид | Богино цагаар ажиллагчид (долоо хоногт 25 хүртэл цаг) | | Урт цагаар ажиллагчид (долоо хоногт 60-аас дээш цаг) | |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо | % | Тоо | % |
| Бүгд | 1 253 023 | 35 367 | 2.8 | 349 098 | 27.9 |
| Эрэгтэй | 669 643 | 12 444 | 1.9 | 232 511 | 34.7 |
| Эмэгтэй | 583 380 | 22 923 | 3.9 | 116 587 | 20.0 |
| Хот | 746 679 | 13 759 | 1.8 | 205 388 | 27.5 |
| Хөдөө | 506 344 | 21 608 | 4.3 | 143 710 | 28.4 |
| Үндсэн салбараар: | | | | | |
| Хөдөө аж ахуйн | 334 101 | 17 474 | 5.2 | 109 577 | 32.8 |
| Үйлдвэрлэлийн | 258 264 | 3 733 | 1.4 | 86 658 | 33.6 |
| Үйлчилгээний салбар | 660 658 | 14 160 | 2.1 | 152 863 | 23.1 |
| Хөдөлмөр эрхлэлтийн байдал: | | | | | |
| Цалин хөлстэй ажиллагч | 639 594 | 5 375 | 0.8 | 128 779 | 20.1 |
| Ажил олгогч | 18 449 | 141 | 0.8 | 7 456 | 40.4 |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 252 001 | 10 409 | 4.1 | 102 086 | 40.5 |
| Нөхөрлөл, хоршооны гишүүн | 536 | 110 | 20.5 | 63 | 11.8 |
| Мал аж ахуй эрхлэгч | 296 567 | 15 683 | 5.3 | 96 159 | 32.4 |
| Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч | 45 327 | 3 451 | 7.6 | 14 417 | 31.8 |
| Эдгээр ангилалд хамрагдах боломжгүй ажиллагч | 549 | 198 | 36.1 | 138 | 25.1 |

## 10.2 ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хүмүүсийг хөдөлмөр эрхлэхэд татан оролцуулах, дур сонирхолтой болгоход шаардлагатай ажлын цагийн нөхцөл бүрдээгүй үед цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт байсаар байдаг. Монгол Улсад сүүлийн жилүүдэд цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид буурсан ч 2017 онд өмнөх оноос 2.7 дахин өсөж, 9.9 мянгад хүрсэн бол 2018 онд өмнөх оноос 18.5 хувиар буурч 8.1 мянгад хүрсэн байна.

Нийт ажиллагчдад эзлэх цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийн хувь 2018 оны байдлаар 0.7 хувьтай байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээл дээр ажиллагчдын нийлүүлэлтийн дутуу ашиглалтыг харуулж байгаа ба ажилгүй иргэдээс гадна тэр хэмжээний эрэлт мөн хөдөлмөрийн зах зээлд байгааг харуулж байна. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийг 2018 оны байдлаар, насны бүлгээр авч үзэхэд залуучууд буюу 35-39 насныхан 1.4 мянга (17.6%) байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна.

**Зураг 10.3. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, насны бүлгээр, хүнээр**




Харин боловсролын хувьд сүүлийн 9 жилийн байдлаар авч үзэхэд, 2013 он хүртэл боловсролгүй, бага, суурь болон бүрэн дунд боловсролтой ажиллагчид зонхилж байсан бол 2014 оноос тодорхой түвшний мэргэжил эзэмшсэн буюу тусгай мэргэжлийн дунд болон техникийн болон мэргэжлийн боловсролын түвшний боловсрол эзэмшсэн хүмүүс өндөр хувийг эзлэх болжээ. Энэ нь сүүлийн жилүүдэд "Төрөөс хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого"-ын хүрээнд мэргэжил олгох сургалтыг хөдөө, орон нутаг болон нийслэлд нэлээдгүй явуулсантай холбоотой байх талтай юм.

**Зураг 10.4. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн тархалт, боловсролын түвшнээр, дунд эзлэх хувиар**




Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар авч үзэхэд мал аж ахуй эрхлэгчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид ихэнх хувийг эзэлж байна.

**Зураг 10.5. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн тархалт, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, дунд эзлэх хувиар**



Харин үндсэн ажлынх нь эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 2010-2012 онуудад хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид зонхилох хувийг эзэлж байсан бол 2013-2016 онуудад үйлчилгээний салбарт ажиллагчид, 2017-2018 онуудад дахин хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид ихэнх хувийг эзэлж байна. Мөн үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувь өссөн байгаа ч 2014 оноос хойш өсөлт, бууралттай хэлбэлзэлтэй байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна. Үйлдвэрлэлийн салбарын өөрчлөлт нь дэлхийн эдийн засгийн хямрал, дэлхийн зах зээл дэх уул уурхайн түүхий эдийн үнийн өөрчлөлтийн улмаас хэлбэлзэлтэй байсан байх талтай юм.

**Хүснэгт 10.2. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар, хувиар**

| Үндсэн салбараар | | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөдөө аж ахуй | | 51.5 | 53.7 | 50.7 | 34.7 | 46.0 | 35.5 | 33.7 | 47.3 | 47.9 |
| Үйлдвэрлэл | | 16.2 | 17.6 | 20.4 | 26.4 | 12.8 | 20.9 | 16.6 | 33.6 | 18.0 |
| Үйлчилгээ | | 32.3 | 28.7 | 28.9 | 38.9 | 41.2 | 43.6 | 49.7 | 19.1 | 34.1 |
| Бүгд | % | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| | Тоо | 10 161 | 8 547 | 10 120 | 5 760 | 3 915 | 2 689 | 3 627 | 9 910 | 8 078 |

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдыг ажил мэргэжлийнх нь хувьд авч үзэхэд хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан ихэнх хувийг эзэлж байна.

# БҮЛЭГ XI

# АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ

Ажиллагчид, салбараар, улирлаар, хувиар



96

## 11.1 ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДАЛ

Судалгааны үр дүнг улирлаар авч үзэхэд ажиллах хүчний оролцооны түвшин судалгааны 4 дүгээр улиралд хамгийн өндөр буюу 61.9 хувь, 1 дүгээр улиралд хамгийн бага буюу 60.6 хувьтай байна. 15 ба түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх өвөл, зуны буюу 1,3 дугаар улиралд бага, 2,4 дүгээр улиралд их байсан байна. Энэ нь мөн тухайн улирлынхаа АХОТ-ны хэлбэлзэлд нөлөөлсөн байна.

**Зураг 11.1 Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр**




| | АХОТ | Эрэгтэй | Эмэгтэй |
|---|---|---|---|
| I | 60.6 | 68.4 | 53.8 |
| II | 61.0 | 69.5 | 53.4 |
| III | 61.3 | 70.2 | 53.4 |
| IV | 61.9 | 70.7 | 53.9 |
| Жилийн дундаж | 61.0 | 69.5 | 53.4 |

## 11.2 АЖИЛЛАГЧИД

Манай улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хандлагыг улирлаар, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь ангилан дараах зурагт харуулав.

**Зураг 11.2. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, улирлаар**




Судалгааны 2 болон 4 дүгээр улиралд ажиллагчид өссөн өсөлт нь эдийн засгийн үйл ажиллагааны салбарын хувьд хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт,

ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдлынх нь хувьд цалин хөлстэй ажиллагчдын хувь өндөр байгаа нь харагдаж байна. Энэ нь Монгол орны хувьд улирлын чанартай хөдөлмөр эрхэлдэгтэй холбоотой юм. Мөн улирлын шинж чанартай, түр ажлын байр бий болдогтой холбоотойгоор иргэдийн эдийн засгийн идэвх ихсэн, эдийн засгийн идэвхгүй хүн амаас ажилгүй иргэдийн эгнээнд шилжих хандлага байдгаас шалтгаална.

15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин хөдөө орон нутагт хот, суурин газрынхаас (15.8-20.1 пунктээр) илүү байгаа нь хөдөө аж ахуй болон үйлдвэрлэлийн салбарт олноороо ажиллаж байгаатай холбоотой юм.

**Зураг 11.3. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин, байршил, улирлаар**




Дээрх зургаас харахад өвлийн буюу 1 дүгээр улирал (20.1 пункт) болон 4 дүгээр улирал (18.5 пункт)-д хөдөө, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн түвшин хот, суурин газрынхаас нилээд өндөр байгаа бол 3 дугаар улиралд хөдөө, орон нутаг болон хот, суурин газрын ялгаа буурсан (15.8 пункт) байна.

## 11.3. АЖИЛГҮЙ ИРГЭД

Судалгаагаар ажилгүйдлийн төлөв байдлын талаар мэдээлэл цуглуулан, ажилгүйдлийн үзүүлэлтүүд, тэдгээрийн цар хүрээг улирлын хэлбэлзлээр гаргав.

### Зураг 11.4. Ажилгүйдлийн түвшин, хүйс, улирлаар, хувиар




| | Улсын дүн | Эрэгтэй | Эмэгтэй |
|---|---|---|---|
| I | 9.7 | 10.4 | 8.9 |
| II | 7.5 | 8.0 | 7.0 |
| III | 6.9 | 7.1 | 6.8 |
| IV | 6.6 | 7.5 | 5.5 |
| Жилийн дундаж | 7.7 | 8.3 | 7.0 |

2018 оны 1 дүгээр улиралд ажилгүйдлийн түвшин хамгийн их буюу 9.7 хувьд хүрч, 4 дүгээр улиралд хамгийн бага буюу 6.6 хувь байна. Хүйсээр нь авч үзвэл 1 дүгээр улиралд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин их байна. Хүн амын ажилгүйдлийн түвшинг хүйсээр авч үзэхэд жилийн бүх улиралд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс (0.3-2.0 пункт) өндөр байгаа бөгөөд энэ ялгаа 4 дүгээр улиралд хамгийн их байна. Харин хот, хөдөөгөөр бүх улиралд хот, суурин газарт хөдөөгийнхөөс (4.0-5.4 пункт)-ээр өндөр байна.

Ажилгүй иргэдийн ажилгүй байгаа шалтгааныг улирлаар харвал бүх улиралд ажил хайгаад олдохгүй байгаа гэсэн шалтгаантай иргэд хамгийн их буюу 44.7-53.6 хувийг эзлэж байна. Мөн мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа шалтгаантай ажилгүй иргэд 11.5-14.5 хувийг эзэлж байна.

### Зураг 11.5. Ажилгүй иргэд, шалтгаанаар, улирлаар, хувиар



# БҮЛЭГ XII
# АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ СҮҮЛИЙН 8 ЖИЛИЙН ҮНДСЭН ҮР ДҮНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Залуучуудын болон нийт ажилгүйдлийн түвшний харьцаа



## 12.1. ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДАЛ

Судалгааны сүүлийн 8 жилийн байдлаарх үр дүнг дараах хүснэгтээс харахад 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх хэлбэлзэж байсан нь ажиллах хүчний оролцооны түвшний өсөлт, бууралтаас харагдаж байна.

**Хүснэгт 12.1. 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх**

| Үзүүлэлтүүд | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | | | | | | | | |
| 15, түүнээс дээш насны хүн ам | 1 798.4 | 1 812.1 | 1 937.1 | 1 941.6 | 2 022.9 | 2 107.0 | 2 220.4 | 2 226.6 |
| Эдийн засгийн идэвхтэй хүн ам | 1 124.7 | 1 151.1 | 1 198.3 | 1 206.6 | 1 243.9 | 1 275.6 | 1 357.4 | 1 358.6 |
| Ажиллагчид | 1 037.7 | 1 056.4 | 1 103.6 | 1 110.7 | 1 151.2 | 1 147.8 | 1 238.3 | 1 253.0 |
| Ажилгүй иргэд | 87.0 | 94.7 | 94.7 | 95.9 | 92.7 | 127.8 | 119.1 | 105.6 |
| Эдийн засгийн идэвхгүй хүн ам | 673.7 | 661.0 | 738.8 | 735.0 | 779.0 | 831.4 | 863.0 | 868.0 |
| Ажиллах хүчний оролцооны түвшин, % | 62.5 | 63.5 | 61.9 | 62.1 | 61.5 | 60.5 | 61.1 | 61.0 |
| Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, % | 55.7 | 58.3 | 57.0 | 57.2 | 56.9 | 54.5 | 55.8 | 56.3 |
| Ажилгүйдлийн түвшин, % | 7.7 | 8.2 | 7.9 | 7.9 | 7.5 | 10.0 | 8.8 | 7.8 |

Ажиллах хүчний түвшин болон оролцооны хэв маяг нь хөдөлмөр эрхлэх боломжууд болон орлогын эрэлт хэрэгцээнээс шалтгаалдаг хэдий ч хүн ам зүйн ангилал хооронд ялгаатай байх талтай. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин бүх талаараа буюу насны бүлэг, гэр бүлийн байдал, боловсролын түвшингийн хувьд эрэгтэйчүүдийнхээс их ялгаатай байдаг. Түүнчлэн хот, хөдөөгийн хүн амын оролцооны түвшин ч гэсэн их зөрүүтэй байдаг байна.

### 12.1.1 АХОТ-ний динамик харьцуулалт, хүйс, насны бүлэг, бүс нутгаар

Ажиллах хүчний оролцооны түвшин 2012 онд хамгийн өндөр (63.5%), 2016 онд хамгийн бага (60.5%) хувьтай байсан бөгөөд 0.2-1.6 пунктны өсөлт, бууралттай хэлбэлзэж байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн АХОТ 2018 онд 69.5 хувь болж 2017 оноос 2.0 пунктээр өссөн байгаа бол эмэгтэйчүүдийн АХОТ өмнөх оноос 1.8 пунктээр буурч 53.4 хувь болжээ.

### Зураг 12.1. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр




Судалгааны сүүлийн 8 жилийн үр дүнгээс харахад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин дунджаар 12.0 /10.6-13.1/ пунктийн зөрүүтэй байсан бол 2018 онд энэ зөрүү 16.1 пункт болж өсчээ.

### Зураг 12.2. Ажиллах хүчний оролцооны түвшин, байршлаар




АХОТ–г байршлаар нь авч үзэхэд хот, суурин газарт 48.5-55.8 хувьтай, хөдөөд үүнээс харьцангуй өндөр 68.9-73.4 хувьтай байгаа нь хот, суурин газарт сургуульд хамрагдалтын түвшин хөдөө орон нутгийнхнаас өндөр, мөн манай орны эдийн засагт голлох үүргийг гүйцэтгэж буй малчид өндөр хувийг эзлээд байгаа нь (2018 онд таван хүний нэг нь малчин) нөлөөлсөн байх талтай.

Залуучуудын (15-24 нас) АХОТ нь тухайн оронд боловсролын боломжууд хэр элбэг байгааг илтгэдэг бол ахимаг насныхны (55-64 нас эсхүл 65-аас дээш нас) АХОТ нь ахмад ажилтнуудын тэтгэвэрт гарах хандлага, тэтгэврийн насны хүмүүст зориулсан нийгмийн хамгааллын сүлжээ байгаа эсэхийг илэрхийлдэг.

**Зураг 12.3. 15-24 насны залуучуудын ажиллах хүчний оролцооны түвшин**




Залуучуудын буюу 15-24 насны хүн амын АХОТ 2011 онд 34.6 хувь байсан бол 2018 онд 30.2 хувь болж 4.4 пунктээр буурсан бол 2017 оноос 1.6 пунктээр өсчээ. 20-24 насны хувьд 52.1 хувиас 52.9 хувьд хүрч 0.8 пунктээр өсч, 15-19 насныхны хувьд 17.8 хувиас 10.6 хувьд хүрч 7.2 пунктээр буурсан байна.

Монгол Улсын Засгийн газраас 2012 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгосонтой холбогдуулан нилээдгүй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсний дотор оюутан, залуучуудыг цагийн ажлаар хангах, байнгын ажлын байртай болгох зорилгоор “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр”-ийн хүрээнд залуучуудын бичил бизнесийг дэмжих болон оюутан, залуучуудыг цагийн болон байнгын ажлын байраар хангах ажил бодлого хэрэгжүүлсэн нь 2012 онд 15-19 насны залуучуудын ажиллах хүчний оролцооны түвшин өндөр гарахад нөлөөлжээ.

**Зураг 12.4. Ахмад настны (55-аас дээш) ажиллах хүчний оролцооны түвшин**



Ахмад настны буюу 55, түүнээс дээш насны хүмүүсийн АХОТ 2011 оноос 2015 он хүртэл аажмаар буурсанч сүүлийн 3 жилд өсч 2018 онд 27.8% хүрсэн байна. Мөн өндөр настны тэтгэвэр авагчид сүүлийн жилүүдэд өсөх хандлага ажиглагдаж байна.

### 12.1.2 АХОТ, боловсролын түвшин болон гэрлэлтийн байдлаар

Сүүлийн 8 жилийн техникийн болон мэргэжлийн боловсрол, түүнээс дээш боловсролтой хүн амын АХОТ улсын дунджаас өндөр байгаа бол тодорхой хэмжээний боловсрол эзэмшээгүй буюу бүрэн дунд, түүнээс бага боловсролтой хүн амын хувьд АХОТ нь улсын дундажаас доогуур байна.

**Зураг 12.5. Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшнээр**




Эмэгтэйчүүдийн АХОТ сүүлийн 8 жилийн байдлаар аажмаар буурсан бол гэр бүл цуцалсан эмэгтэйчүүдийн АХОТ 2013 онд хамгийн өндөр түвшинд (75.4%) хүрсэн бол 2018 онд 70.0% болжээ.

**Хүснэгт 12.2. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, гэрлэлтийн байдлаар**

| Үзүүлэлтүүд | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Огт гэрлээгүй | 40.6 | 46.7 | 41.6 | 40.1 | 34.5 | 35.1 | 35.0 | 34.6 |
| Гэрлэсэн: | | | | | | | | |
| - Батлуулсан | 76.9 | 75.6 | 75.1 | 75.2 | 67.8 | 65.5 | 68.1 | 65.4 |
| - Батлуулаагүй | 72.1 | 69.4 | 66.3 | 68.1 | 58.9 | 57.3 | 51.1 | 58.2 |
| Тусгаарласан | 76.2 | 72.9 | 69.0 | 75.4 | 74.1 | 69.7 | 62.3 | 61.1 |
| Цуцалсан | 69.9 | 69.7 | 75.4 | 69.7 | 70.4 | 66.8 | 69.2 | 70.0 |
| Бэлбэсэн | 36.6 | 35.7 | 32.2 | 32.6 | 30.7 | 31.3 | 31.3 | 29.9 |
| Бүгд | 62.5 | 63.5 | 61.9 | 62.1 | 55.4 | 54.2 | 55.2 | 53.4 |

## 12.2 АЖИЛЛАГЧИД

Ажиллах хүчний судалгааны 2018 оны үр дүнгээрх 15 ба түүнээс дээш насны ажиллагчдыг 2017 онтой харьцуулахад 1.2 хувиар өсөж, 1253.0 мянгад хүрчээ. Ажиллагчдыг хот, хөдөөгөөр 2017 онтой харьцуулж авч үзэхэд хот суурин газарт ажиллагчид 2018 онд 746.7 мянгад хүрч 1.8 хувиар, хөдөө орон нутагт ажиллагчид 506.3 мянгад хүрч 0.3 хувиар өссөн байна.

**Зураг 12.6. Ажиллагчид, байршлаар, дүнд эзлэх хувиар**




Ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзэхэд 2018 онд өмнөх оноос өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч 7.7(20.4%) мянгаар өссөн, ажил олгогчид 6.3(51.8%) мянгаар өссөн бол мал аж ахуй эрхлэгч 26.2(8.1%) мянгаар буурсан нь хамгийн өндөр өөрчлөлттэй байна.

**Зураг 12.7. Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, дүнд эзлэх хувиар**




*-Нөхөрлөл Хоршооны гишүүдийг энэ ангилалд оруулан тооцсон

2018 оны байдлаар үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын эзлэх хувь 2017 оноос 20.3(8.5%), үйлчилгээний салбарт ажиллагчид 16.8(2.6%) мянгаар өссөн байна. Харин хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын эзлэх хувь 2017 оноос 22.3(6.3%) мянгаар буурчээ.

**Зураг 12.8. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар, хувиар**




## 12.3 АЖИЛГҮЙ ИРГЭД

2018 оны судалгааны дүнгээр ажилгүйдлийн түвшин 7.8 хувьд хүрсэн нь өмнөх оноос 1.0 пунктээр буурсан. Уг бууралтад ажиллагчдын тоо өмнөх оноос 14.7 мянгаар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

**Хүснэгт 12.3. Залуучуудын болон нийт ажилгүйдлийн түвшний харьцаа**

| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт ажилгүйдлийн түвшин (15+) | 7.7 | 8.2 | 7.9 | 7.9 | 7.5 | 10.0 | 8.8 | 7.8 |
| Залуучуудын ажилгүйдлийн түвшин (15-24) | 15.6 | 14.0 | 16.6 | 17.4 | 17.9 | 25.1 | 22.7 | 20.4 |
| Залуучуудын болон нийт ажилгүйдлийн түвшний харьцаа | 2.0 | 1.7 | 2.1 | 2.2 | 2.4 | 2.5 | 2.6 | 2.6 |

Залуучуудын болон үндэсний ажилгүйдлийн түвшинг харьцуулсан байдлаар *Зураг 12.9*-д үзүүлэв. Босоо тэнхлэгт залуучуудын ажилгүйдлийн түвшин (15-24 насныхан), хэвтээ тэнхлэгт нийт хүн амын ажилгүйдлийн түвшин (15 ба түүнээс дээш насны)-г харуулав. Саарал талбай нь залуучуудын ажилгүйдлийн түвшин нь үндэсний ажилгүйдлийн түвшингээс бага харин цэнхэр талбай нь залуучуудын ажилгүйдлийн түвшин нь үндэсний ажилгүйдлийн түвшингээс их боловч 2 дахин их биш байгааг харуулна. Харин шар талбай нь залуучуудын ажилгүйдлийн түвшин нь үндэсний ажилгүйдлийн түвшингээс өндөр буюу 2-3 дахин их, улаан талбай нь залуучуудын

ажилгүйдлийн түвшин нь үндэсний ажилгүйдлийн түвшингээс 3-аас дээш дахин их буюу тухайн улсын залуучуудын ажилгүйдэл хүнд байгаа харуулдаг.

**Зураг 12.9. Үндэсний болон залуучуудын ажилгүйдлийн түвшний харьцаа, хувиар**




2012 онд залуучуудын ажилгүйдлийн түвшин үндэсний ажилгүйдлийн түвшингээс их боловч 2 дахин их биш байна. Бусад онуудад залуучуудын ажилгүйдэл өндөр буюу 2-3 дахин их байна.

**Зураг 12.10. Ажилгүйдлийн түвшин, хүйсээр**



Сүүлийн 8 жилд 2013 оноос бусад онуудад эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс ямагт өндөр байсан байна.

**Зураг 12.11. Ажилгүйдлийн түвшин, байршлаар**




2011 онд хотод ажилгүйдлийн түвшин хөдөөгөөс 1.3 пунктээр өндөр байсан бол 2012 онд 3.2 пункт болж өсөж 2013 онд ажилгүйдлийн түвшин хотод 8.3 хувь, хөдөөд 7.6 хувь (0.7 пунктын зөрүү) болж буурч иржээ. Үүнээс хойш уг зөрүү аажмаар өсөж 2016 онд 5.4 пункт болж, ажилгүйдлийн түвшин хотод 12.2 хувьд хүрээд байсан бол 2018 онд хот, хөдөөгийн ялгаа 4.2 пункт болж хотын ажилгүйдлийн түвшин 9.4 хувьд хүрээд байна.

Урт хугацааны ажилгүйдлийн үзүүлэлт нь ажилгүйдлийн нийт хугацаа, өөрөөр хэлбэл тухайн хүний ажилгүй байгаа болон ажил хайж байгаа үеийн хугацааны талаар авч үздэг. Урт хугацааны ажилгүйдэл нь нэг жилээс илүү урт хугацаагаар ажил эрхлээгүй буюу урт хугацааны ажилгүйдэл, өөр бусад хугацаанд хамаарах ажилгүйдэл гэсэн хоёр үзүүлэлтээс бүрдэнэ. Энэхүү үзүүлэлт нь хөдөлмөрийн зах зээл дээр хүндрэл, бэрхшээлтэй тулгарч буй бүлэг хүмүүсийн талаарх мэдээлэл болж өгдөг.

**Зураг 12.12. Ажилгүй иргэд, ажил хийх боломжтой байсан хугацаагаар, хувиар**




Сүүлийн жилүүдэд урт хугацаанд (12, түүнээс дээш сараар) хөдөлмөр эрхлээгүй ажилгүй иргэдийн дунд эзлэх хувь нь буурсан хандлагтай байна. Өөрөөр хэлбэл, 2011 онд нийт ажилгүй иргэдэд урт хугацаанд ажилгүй байгаа иргэд 64.4(74.1%) мянгыг эзлэж байсан бол тоон үзүүлэлтээр өсч, дунд эзлэх хувь нь буурч 2018 онд энэ үзүүлэлт 65.3(61.8%) мянгад хүрсэн байна. Гэсэн хэдийч энэ үзүүлэлт нь өндөр хэвээр, анхаарах асуудлын нэг байсаар байна. Түүнчлэн 3, түүнээс дээш жилээр ажилгүй байгаа иргэд өндөр хувийг эзэлсээр байна.

Залуучуудын хувьд урт хугацааны ажилгүйдэлд өртөх нь насанд хүрэгчдийг бодвол харьцангүй бага байна. 2011 онд урт хугацаагаар буюу 12, түүнээс дээш сараар ажилгүй байгаа залуучууд нийт ажилгүй байгаа залуучуудын 15.2(60.1%) мянгыг эзэлж байсан бол үүнээс хойш аажмаар буурч 2018 онд 11.8(44.2%) болж буурчээ.

**Зураг 12.13. Ажилгүй 15-24 насны залуу иргэдийн хувь, ажил хийх боломжтой байсан хугацаагаар**



# БҮЛЭГ XIII

# СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

## Судалгаанд хамрагдсан нийт өрх




**Судалгаанд хамрагдсан өрхийн тоо**
**12 816**

## 13.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

АХС нь өрхөд суурилсан судалгаа учир түүвэрлэлтийн нэгж нь өрх байна. Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа /хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж, амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа/ иргэдийг өрхийн гишүүнд тооцохгүй.

## 13.2 ТҮҮВЭРЛЭЛТ

Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэглэлтийг засаг захиргааны нэгж буюу бүх аймаг, Улаанбаатар хотын дүүргүүд байхаар хийсэн. Энэ нь бодлого боловсруулагчдад хөдөлмөрийн статистикийн түлхүүр үзүүлэлтүүд тухайлбал, ажилгүйдлийг аймаг, дүүргээр гаргаж өгөх боломжийг бүрдүүлэх юм. Энд Улаанбаатар хотын дүүрэг, хорооны бүх хэсгүүд, аймгийн түвшинд сумын нийт багууд нь ТАШН болж байгаа юм. Ажиллах хүчний түүвэр судалгаанд 12816 өрх хамрагдсан бөгөөд улирал тутам 3204 өрх шинээр түүвэрлэгдсэн болно. Судалгааны түүвэрлэлтийн хүрээ нь Монгол Улсын нийт өрх бөгөөд үүнд Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн 2016 оны жилийн тайлан, мэдээний үр дүнг ашигласан.

Түүвэрт хэдий хэмжээний нэгж /өрх/ хамрагдах нь судалгааны санхүүжилт болон түүвэр судалгааны үр дүнгийн нарийвчлалаас ихээхэн хамаарна. Судалгаанд хамрагдсан 12816 өрхөөс авсан мэдээлэл нь Монгол Улсын нийт өрхийг төлөөлөхдөө судалгааны асуулгаар цуглуулсан мэдээллийн бодит байдлын алдааны магадлал нь үндэсний хэмжээнд 5 хувиас хэтрэхгүй ба түүвэрлэлтийн загварын нөлөөний утга нь 1.5 хувиас хэтрэхгүй байхаар түүвэрлэлт хийсэн.

### Бүлэглэлт:

Улаанбаатар хотын хэмжээнд дүүрэг тус бүр түүврийн бүлэг болох бөгөөд өмнө дурьдсаны дагуу хамгийн цөөн өрх, хүн амтай 2 дүүргийг нэгтгэн нэг бүлэг болгон нийт 8 бүлэг үүсгэсэн. 21 аймаг тус бүрийг нэг бүлэг хэмээн тооцож 21 бүлэг үүсгэсэн юм. Нийтдээ 21+8=29 бүлгээс 2 үе шаттай түүвэр хийсэн.

Бүлэг 1: УБ хотын Хан-Уул дүүргийн бүх хэсгүүд

Бүлэг 2: УБ хотын Багахангай болон Багануур дүүргийн бүх хэсгүүд

..........................................................................

Бүлэг 7: УБ хотын Чингэлтэй дүүргийн бүх хэсгүүд

Бүлэг 8: УБ хотын Сонгинохайрхан дүүргийн бүх хэсгүүд

Бүлэг 9: Архангай аймгийн бүх багууд

Бүлэг 10: Баян-Өлгий аймгийн бүх багууд

..........................................................................

Бүлэг 29: Говьсүмбэр аймгийн бүх багууд

Түүвэрлэлтийг хийхдээ 2 шатлалт түүврийн аргыг хэрэглэсэн. Эхний шатанд ТАШН, хоёр дахь шатанд түүвэрлэгдсэн анхан шатны нэгж дэх өрхийг сонгосон. Түүвэрлэлтийн эхний шатанд судалгааны нэгж /баг, хорооны хэсэг/ буюу ТАШН-ийг түүвэрлэлтийн пропорциональ магадлалт системчилсэн түүврийн аргаар бүлэг тус бүрт түүвэрлэлт хийсэн. Ийнхүү түүвэрлэлт хийхдээ албан бус хөдөлмөр эрхлэлтийн сонгогдох магадлалыг нэмэгдүүлэх зорилгоор дэд бүлэглэлтийг хийж өглөө. Хөдөө аж ахуйн бус чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхэлдэг гишүүнтэй өрхийн хувийн жинг тодорхойлогч үзүүлэлт болгон сонгож авсан.

Бүлэг доторх судалгааны бүх нэгжийг аймаг, сум, баг, хорооны хэсгийн нэрийн дагуу жагсааж, судалгааны нэгж бүрт тоологдсон өрхийн тоог тавьж түүврийн хүрээг бэлтгэсэн.

Хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар анхан шатны нэгжийг сонгоход ТАШН дэх хүн амын тоо $\boldsymbol{M_h}$- г хэмжээний тодорхойлогч болгон ашигласан. Бүлэглэлт тус бүрээс хэмжээнд нь пропорциональ магадлалт системчилсэн түүврийн арга/ХПМСТА/-ыг хэрэглэсэн болно.

Түүвэрлэлтийн үйл ажиллагааг дараах байдлаар үзүүлэв.

"$\boldsymbol{h}$" бүлэг доторх "$\boldsymbol{i}$" ТАШН-ийн түүвэрлэгдэх магадлал дараах томьёогоор илэрхийлэгдэнэ.

$$\boldsymbol{P_h^{(i)}} = \frac{\boldsymbol{a_h M_h}}{\boldsymbol{M_h}}$$

Үүнд:

$\boldsymbol{a_h}$ - бүлэг тус бүрээс авсан ТАШН-ийн тоо

$\boldsymbol{M_h}$ - '$\boldsymbol{i}$' ТАШН-д түүврийн хүрээнд тодорхойлогдсон хүн амын тоо

$\boldsymbol{M_{h=}} \sum \boldsymbol{M_h}$ - бүлэг бүр дэх түүврийн хүрээгээр тогтоогдсон нийт хүн амын тоо

"$\boldsymbol{h}$" бүлэг дэх ТАШН-үүдийг аймаг, сумын нэрийн дагуу жагсааж ТАШН-ийн түүвэрлэлтийг хийсэн ба тогтоогдсон хүн амын тоог хэмжээний үзүүлэлт $\boldsymbol{M_h}$ болгож авсан юм. "$\boldsymbol{M_h}$" өсөн нэмэгдэх утгуудыг тооцоолж уг утгуудыг ТАШН тус бүрийн хаpалдаа тавьсан болно. Түүврийн интервал $\boldsymbol{I_h}$ -ийг дараах байдлаар тооцоолсон.

$\boldsymbol{I_h} = \frac{\boldsymbol{M_h}}{\boldsymbol{a_h}}$ - хамгийн ойр бүхэл тоонд шилжүүлнэ.

"$R_h$" – санамсаргүй тоо нь 0-ээс $I_h$ хүртэлх дурын тоо байх ба үүнийг Excel программын санамсаргүй тооны функцийн тусламжтайгаар тодорхойлов. "$a_h$" тодорхойлогч тоонуудын дараалыг өмнөх сонгогдсон тоон дээр $\mathbf{I_{h1}}$ –г нэмж олсон болно.

$$R_h, (R_h + I_{h1}), (R_h + 2I_{h1}), (R_h + 3I_{h1}), \dots (R_h + (j-1)I_{h1}), (R_h + (a_h - 1)I_{h1})$$

Хоёр дахь шатанд сонгогдсон ТАШН бүрээс түүвэр олонлогийг бүрдүүлэх өрхүүдийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгосон. ТАШН-үүдээс ирүүлсэн өрхийн жагсаалтанд үндэслэн санамсаргүйгээр 12 өрхийг сонгож, судалгаанд хамруулсан.

## Түүврийн жин

Судалгааны түүврийн жин доорх томьёоны дагуу тодорхойлогдоно.

1. Дэд түүвэрлэлт тус бүр дэх түүврийн анхан шатны жин тооцох томьёо

$$M_{srij} = \frac{P_s \times H_{srij}}{n_s \times p_{sri} \times h_{srij}}$$

2. Дэд түүвэрлэлтийг нэгтгэсэн түүврийн анхан шатны нэгжийн жин тооцох томьёо

$$M_{sij} = \frac{1}{2} \times \frac{P_s \times H_{srij}}{n_s \times p_{sri} \times h_{srij}}$$

3. t – р улирлын жин тооцох томьёо

$$M_{tsij} = \frac{1}{2} \times \frac{P_s \times H_{srij}}{n_{tsr} \times p_{sri} \times h_{srij}}$$

Энд $P, p, n, H$ & $h$ -ийн утгууд:

- $P$ – тухайн бүлгийн хэмжээ буюу бүлгийн нийт хүн амын тоо
- $p$ – тухайн анхан шатны нэгж дэх нийт хүн амын тоо
- $n$ – тухайн дэд түүвэрлэлтээр тоологдох түүврийн анхан шатны нэгжийн тоо
- $H$ – тухайн бүлгийн анхан шатны нэгжийн дэд түүвэрлэлт дэх нийт өрхийн тоо
- $h$ – тухайн бүлгийн анхан шатны нэгжийн дэд түүвэрлэлт дэх түүвэрлэгдэх өрхийн тоо

### Вариац болон стандарт алдааны тооцоо

Судалгааны үр дүнгийн нарийвчлал, төлөөлөх чадварыг гаргах нь тооцооны зайлшгүй хэсэг юм.

Тухайн сонгож авсан “$\boldsymbol{y}$” үзүүлэлтийн вариацыг тооцох томьёо:

$$var(y) = \sum_h \left[ (1 - f_h) \left( \frac{a_h}{a_h - 1} \right) \sum_i \left( y_{hi}^2 - \frac{y_h^2}{a_h} \right) \right]$$

Энд:

- $f_h$ – “$h$” бүлгийн түүврийн хувь
- $a_h$ – “$h$” бүлгээс түүвэрлэсэн ТАШН-ийн тоо
- $y_{hi}$ – “$h$” бүлгийн “$i$” тооллогын нэгжийн “$y$” үзүүлэлтийн утга

Судалгааны үр дүнгийн стандарт алдааны утга нь түүвэр хийснээс шалтгаалан ерөнхий олонлогийн бодит утга буюу параметрээс түүврийн утга хэр зэрэг хэлбэлзэж байгааг үзүүлнэ. Стандарт алдаа($se(y)$)-г түүврийн үндсэн дээр

$se(y) = var(y)^{1/2}$ гэсэн томьёогоор тооцно.

Харьцангуй стандарт алдаа буюу вариацын коэффициент нь $cv$, түүврийн тооцооны утгын харьцангуй вариацын утгыг илэрхийлэх ба өөрөөр хэлбэл түүврийн алдаа нь тооцооны утгатайгаа харьцуулахад ямархуу далайцтай байна гэдгийг үзүүлнэ. Вариацын коэффициентыг дараах аргаар тооцно.

$$cv(y) = se(y)/y$$

Дундаж харьцаа гэх мэт үзүүлэлтийн тооцооны утгын далайц, хэмжих нэгж нь өөр өөр байдгаас хамааран тухайн судлагдаж байгаа үзүүлэлтийн талаар хийгдсэн янз бүрийн судалгааны үр дүнгийн стандарт алдаануудыг шууд харьцуулах боломж олгодог. Түүврийн хэмжээ болон түүврийн арга нь түүврийн алдаа хэр зэрэг их, бага байхыг тодорхойлох бөгөөд зарим үзүүлэлтийн хувьд түүврийн алдаа өндөр байх боломжтой учир эдгээр тоог ашиглахдаа анхааралтай байх хэрэгтэй.

## 13.3 ТҮҮВРИЙН АЛДАА

Түүвэр судалгаа хийгдэж байгаатай уялдан дараах 2 төрлийн алдаа гарч байдаг.

Үүнд:

1) Түүврийн алдаа;
2) Түүвэрлэлтийн бус алдаа;

Түүвэрлэлтийн бус алдаа нь тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах үйл явцын үед гардаг. Энэхүү алдаанд судалгааны бэлтгэл үе шат, мэдээлэл цуглуулах үед хийсэн судлаач, мэдээллэгчийн санамсаргүй болон санаатай хийсэн алдаа, боловсруулалтын шатанд гарсан алдааг хамруулан авч үздэг. Түүвэрлэлтийн

бус алдаа нь гарсаар байдаг бөгөөд судалгааг явуулах бүхий л үе шатанд багасгах арга хэмжээг авдаг. Нөгөөтэйгүүр түүвэрлэлтийн бус алдааг статистикийн аргаар тооцоолох боломж хомс байдаг. Харин түүврийн алдааг статистикийн аргаар тооцоолдог.

Нийт олонлогоос түүвэрлэн авсан ажиглалт дээр тулгуурлан үр дүнг тооцдогоос улбаалан түүврийн алдаа гардаг. Түүврийн алдаа тухайн судалгааг хийхэд ашигласан түүврийн төрөл болон түүврийн хэмжээнээс хамаарна. Энэхүү алдааг боломжит бага түвшинд байлгах үүднээс түүврийн загвар болон түүврийн хэмжээг сонгосон.

Улсын хэмжээнд тодорхойлогдсон түүврийн анхан шатны нэгжээс судалгаа авч үр дүнг тооцсонтой холбоотойгоор судалгааны үр дүн бодит утгаас ямар хэмжээний хэлбэлзэлтэй байгааг түүвэрлэлтийн алдаа илэрхийлнэ. Түүврийн загвар болон түүврийн хэмжээнд тулгуурлан алдааг тооцсон бөгөөд зарим нэг үзүүлэлтийн алдааны хязгаар өндөр байх нь түүврийн загварыг сонгох үе шатанд харагдаж байсан.

Судалгааны түүвэрлэлтийн алдааг дараах үзүүлэлтийн тусламжтайгаар тооцоолсон бөгөөд түүврийн алдааг илэрхийлэх гол үзүүлэлт нь вариацийн коэффициент болно.

- Ерөнхийн олонлогийн үзүүлэлтийн тооцооны утга
- Стандарт алдаа
- Вариацийн коэффициент
- 95 хувийн итгэмжлэгдэх интервал
- Тооцоо хийхэд ашиглагдсан ажиглалтын тоо

Түүвэрлэлтийн алдааг судалгааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд улсын түвшин, хот, хөдөө, хүйс, бүс нутаг, аймгийн хэмжээнд гэсэн ангиллаар тооцсон.

## Ажиллах хүч

| | Тооцооны утга | Ажиглалтын тоо | Стандарт алдаа | 95% итгэмжлэгдэх магадлал | | Вариацийн коэффициент |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Доод | Дээд | |
| НИЙТ | 1 358 635 | 19 224 | 149.4 | 1 358 337 | 1 358 934 | 0.8 |
| БАЙРШИЛ | | | | | | |
| Хот | 824 366 | 9 573 | 99.2 | 824 168 | 824 564 | 1.0 |
| Хөдөө | 534 269 | 9 651 | 95.2 | 534 079 | 534 460 | 1.0 |
| ХҮЙС | | | | | | |
| Эрэгтэй | 730 590 | 10 255 | 92.4 | 730 405 | 730 775 | 0.9 |
| Эмэгтэй | 628 045 | 8 969 | 83.2 | 627 879 | 628 212 | 0.9 |
| БҮС | | | | | | |
| Баруун | 193 754 | 3 826 | 61.7 | 193 631 | 193 878 | 1.6 |
| Хангай | 280 691 | 4 296 | 66.9 | 280 557 | 280 825 | 1.6 |
| Төв | 234 187 | 4 422 | 67.4 | 234 052 | 234 322 | 1.5 |
| Зүүн | 94 656 | 1 788 | 49.3 | 94 558 | 94 755 | 2.8 |
| Улаанбаатар | 555 347 | 4 892 | 64.8 | 555 217 | 555 476 | 1.3 |
| АЙМАГ | | | | | | |
| Архангай | 46 267 | 842 | 23.4 | 46 220 | 46 314 | 2.8 |
| Баян-Өлгий | 55 772 | 898 | 22.2 | 55 728 | 55 817 | 2.5 |
| Баянхонгор | 44 734 | 736 | 30.3 | 44 673 | 44 795 | 4.1 |
| Булган | 29 481 | 653 | 22.1 | 29 436 | 29 525 | 3.4 |
| Говь-Алтай | 28 626 | 669 | 31.1 | 28 563 | 28 688 | 4.6 |
| Дорноговь | 31 336 | 660 | 23.1 | 31 290 | 31 383 | 3.5 |
| Дорнод | 32 190 | 553 | 24.6 | 32 141 | 32 239 | 4.5 |
| Дундговь | 24 547 | 813 | 23.4 | 24 500 | 24 593 | 2.9 |
| Завхан | 33 295 | 746 | 25.7 | 33 244 | 33 347 | 3.4 |
| Өвөрхангай | 59 034 | 837 | 27.3 | 58 979 | 59 088 | 3.3 |
| Өмнөговь | 32 020 | 617 | 18.7 | 31 983 | 32 058 | 3.0 |
| Сүхбаатар | 29 282 | 710 | 22.7 | 29 237 | 29 328 | 3.2 |
| Сэлэнгэ | 48 597 | 704 | 20.6 | 48 556 | 48 638 | 2.9 |
| Төв | 50 992 | 822 | 21.1 | 50 950 | 51 034 | 2.6 |
| Увс | 36 435 | 752 | 22.1 | 36 391 | 36 479 | 2.9 |
| Ховд | 39 626 | 761 | 17.1 | 39 592 | 39 660 | 2.2 |
| Хөвсгөл | 61 137 | 600 | 28.7 | 61 080 | 61 195 | 4.8 |
| Хэнтий | 33 184 | 525 | 28.2 | 33 128 | 33 240 | 5.4 |
| Дархан-Уул | 39 223 | 506 | 25.3 | 39 172 | 39 273 | 5.0 |
| Улаанбаатар | 555 347 | 4 892 | 64.8 | 555 217 | 555 476 | 1.3 |
| Орхон | 40 039 | 628 | 20.1 | 39 998 | 40 079 | 3.2 |
| Говьсүмбэр | 7 472 | 300 | 19.1 | 7 434 | 7 510 | 6.4 |

## Ажиллагчид

| | Тооцооны утга | Ажиглалтын тоо | Стандарт алдаа | 95% итгэмжлэгдэх магадлал | | Вариацийн коэффициент |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Доод | Дээд | |
| НИЙТ | 1 253 023 | 17 718 | 152.3 | 1 252 718 | 1 253 327 | 0.9 |
| БАЙРШИЛ | | | | | | |
| Хот | 746 679 | 8 563 | 92.2 | 746 495 | 746 864 | 1.1 |
| Хөдөө | 506 343 | 9 155 | 99.1 | 506 145 | 506 542 | 1.1 |
| ХҮЙС | | | | | | |
| Эрэгтэй | 669 643 | 9 408 | 94.8 | 669 453 | 669 832 | 1.0 |
| Эмэгтэй | 583 380 | 8 310 | 81.3 | 583 218 | 583 543 | 1.0 |
| БҮС | | | | | | |
| Баруун | 176 523 | 3 504 | 61.5 | 176 400 | 176 646 | 1.8 |
| Хангай | 260 671 | 3 991 | 73.6 | 260 524 | 260 818 | 1.8 |
| Төв | 216 377 | 4 105 | 72.1 | 216 232 | 216 521 | 1.8 |
| Зүүн | 86 398 | 1 635 | 50.6 | 86 297 | 86 499 | 3.1 |
| Улаанбаатар | 513 054 | 4 483 | 61.1 | 512 931 | 513 176 | 1.4 |
| АЙМАГ | | | | | | |
| Архангай | 43 859 | 798 | 28.7 | 43 802 | 43 916 | 3.6 |
| Баян-Өлгий | 48 758 | 784 | 26.4 | 48 705 | 48 811 | 3.4 |
| Баянхонгор | 41 457 | 684 | 32.0 | 41 393 | 41 521 | 4.7 |
| Булган | 27 304 | 606 | 23.4 | 27 257 | 27 351 | 3.9 |
| Говь-Алтай | 26 896 | 629 | 31.7 | 26 832 | 26 959 | 5.0 |
| Дорноговь | 29 679 | 625 | 22.7 | 29 633 | 29 724 | 3.6 |
| Дорнод | 30 154 | 518 | 26.3 | 30 101 | 30 206 | 5.1 |
| Дундговь | 23 328 | 773 | 24.7 | 23 278 | 23 377 | 3.2 |
| Завхан | 31 868 | 715 | 26.7 | 31 815 | 31 921 | 3.7 |
| Өвөрхангай | 55 881 | 792 | 30.9 | 55 819 | 55 943 | 3.9 |
| Өмнөговь | 29 680 | 572 | 19.8 | 29 641 | 29 720 | 3.5 |
| Сүхбаатар | 26 798 | 650 | 22.4 | 26 754 | 26 843 | 3.4 |
| Сэлэнгэ | 45 880 | 664 | 19.3 | 45 842 | 45 919 | 2.9 |
| Төв | 49 685 | 801 | 21.9 | 49 642 | 49 729 | 2.7 |
| Увс | 32 712 | 677 | 27.4 | 32 657 | 32 767 | 4.0 |
| Ховд | 36 289 | 699 | 16.6 | 36 256 | 36 323 | 2.4 |
| Хөвсгөл | 57 235 | 563 | 32.1 | 57 171 | 57 299 | 5.7 |
| Хэнтий | 29 446 | 467 | 30.3 | 29 385 | 29 507 | 6.5 |
| Дархан-Уул | 31 527 | 405 | 20.8 | 31 485 | 31 568 | 5.1 |
| Улаанбаатар | 513 054 | 4 483 | 61.1 | 512 931 | 513 176 | 1.4 |
| Орхон | 34 935 | 548 | 18.8 | 34 897 | 34 973 | 3.4 |
| Говьсүмбэр | 6 597 | 265 | 18.0 | 6 561 | 6 633 | 6.8 |

## Ажилгүй иргэд

| | Тооцооны утга | Ажиглалтын тоо | Стандарт алдаа | 95% итгэмжлэгдэх магадлал Доод | 95% итгэмжлэгдэх магадлал Дээд | Вариацийн коэффициент |
|---|---|---|---|---|---|---|
| НИЙТ | 105 613 | 1 506 | 43.4 | 105 526 | 105 700 | 2.9 |
| БАЙРШИЛ | | | | | | |
| Хот | 77 687 | 1 010 | 36.8 | 77 613 | 77 760 | 3.6 |
| Хөдөө | 27 926 | 496 | 22.1 | 27 882 | 27 970 | 4.5 |
| ХҮЙС | | | | | | |
| Эрэгтэй | 60 948 | 847 | 24.6 | 60 898 | 60 997 | 2.9 |
| Эмэгтэй | 44 665 | 659 | 19.6 | 44 626 | 44 704 | 3.0 |
| БҮС | | | | | | |
| Баруун | 17 231 | 322 | 12.9 | 17 205 | 17 257 | 4.0 |
| Хангай | 20 020 | 305 | 12.3 | 19 995 | 20 044 | 4.0 |
| Төв | 17 810 | 317 | 10.4 | 17 789 | 17 831 | 3.3 |
| Зүүн | 8 258 | 153 | 6.8 | 8 245 | 8 272 | 4.4 |
| Улаанбаатар | 42 293 | 409 | 11.4 | 42 270 | 42 316 | 2.8 |
| АЙМАГ | | | | | | |
| Архангай | 2 408 | 44 | 4.4 | 2 399 | 2 417 | 10.1 |
| Баян-Өлгий | 7 014 | 114 | 10.6 | 6 993 | 7 035 | 9.3 |
| Баянхонгор | 3 277 | 52 | 7.7 | 3 261 | 3 292 | 14.8 |
| Булган | 2 177 | 47 | 3.7 | 2 169 | 2 184 | 7.9 |
| Говь-Алтай | 1 730 | 40 | 3.1 | 1 724 | 1 736 | 7.7 |
| Дорноговь | 1 658 | 35 | 1.8 | 1 654 | 1 661 | 5.0 |
| Дорнод | 2 036 | 35 | 3.0 | 2 030 | 2 042 | 8.6 |
| Дундговь | 1 219 | 40 | 2.8 | 1 214 | 1 225 | 6.9 |
| Завхан | 1 427 | 31 | 1.6 | 1 424 | 1 431 | 5.3 |
| Өвөрхангай | 3 152 | 45 | 2.9 | 3 146 | 3 158 | 6.5 |
| Өмнөговь | 2 340 | 45 | 3.3 | 2 333 | 2 346 | 7.3 |
| Сүхбаатар | 2 484 | 60 | 3.8 | 2 476 | 2 491 | 6.3 |
| Сэлэнгэ | 2 716 | 40 | 3.1 | 2 710 | 2 723 | 7.9 |
| Төв | 1 307 | 21 | 1.4 | 1 304 | 1 310 | 6.5 |
| Увс | 3 723 | 75 | 6.5 | 3 710 | 3 736 | 8.7 |
| Ховд | 3 337 | 62 | 4.1 | 3 329 | 3 345 | 6.5 |
| Хөвсгөл | 3 903 | 37 | 5.9 | 3 891 | 3 914 | 16.0 |
| Хэнтий | 3 738 | 58 | 4.8 | 3 728 | 3 748 | 8.2 |
| Дархан-Уул | 7 696 | 101 | 8.5 | 7 679 | 7 713 | 8.4 |
| Улаанбаатар | 42 293 | 409 | 11.4 | 42 270 | 42 316 | 2.8 |
| Орхон | 5 104 | 80 | 6.5 | 5 091 | 5 117 | 8.1 |
| Говьсүмбэр | 875 | 35 | 4.8 | 865 | 884 | 13.6 |


Увс
72.6
Баян-Өлгий
70.0
Хөвсгөл
66.2
Сэлэнгэ
64.0
Орхон
64.2
Дархан-Уул
52.1
Завхан
73.4
Булган
74.4
Улаанбаатар
53.4
Хэнтий
55.8
Дорнод
54.1
Ховд
73.9
Архангай
77.8
Төв
78.9
Говь-Алтай
73.3
60.5
Баянхонгор
Өвөрхангай
74.3
Говьсүмбэр
59.8
Сүхбаатар
71.8
Дундговь
79.6
Дорноговь
67.3
Өмнөговь
69.0
Ажиллах хүчний оролцооны түвшин
75.0 - 79.9
70.0 - 74.9
65.0 - 69.9
60.0 - 64.9
55.0 - 59.9
50.0 - 54.9


Увс
10.2
Баян-Өлгий
12.6
Хөвсгөл
6.4
Сэлэнгэ
5.6
Орхон
12.7
Дархан-Уул
19.6
Завхан
4.3
Булган
7.4
Улаанбаатар
7.6
Хэнтий
11.3
Дорнод
6.3
Ховд
8.4
Архангай
5.2
Төв
2.6
Говь-Алтай
6.0
7.3
Баянхонгор
Өвөрхангай
5.3
Говьсүмбэр
11.7
Сүхбаатар
8.5
Дундговь
5.0
Дорноговь
5.3
Өмнөговь
7.3
Ажилгүйдлийн түвшин
15.0 - 19.9
10.0 - 14.9
5.0 - 9.9
1.0 - 4.9

## ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1. Ажил эрхэлдэг хүнтэй өрх, өрхийн ам бүл, өрхөд ажил эрхэлж байгаа хүнээр

| Өрхийн ам бүл | Ажил эрхэлдэг иргэнтэй өрх | Үүнээс: ажил эрхэлдэг 1 хүнтэй өрх | ажил эрхэлдэг 2 хүнтэй өрх | ажил эрхэлдэг 3 хүнтэй өрх | ажил эрхэлдэг 4 түүнээс дээш хүнтэй өрх | Ажиллагчид |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 53 087 | 100.0 | - | - | - | 53 087 |
| 2 | 116 186 | 52.8 | 47.2 | - | - | 171 051 |
| 3 | 150 666 | 44.1 | 47.4 | 8.5 | - | 247 604 |
| 4 | 199 915 | 36.7 | 54.2 | 7.6 | 1.4 | 347 338 |
| 5 | 136 757 | 33.1 | 54.8 | 9.6 | 2.5 | 248 655 |
| 6 | 62 205 | 33.5 | 47.2 | 12.7 | 6.7 | 121 120 |
| 7 | 18 971 | 31.5 | 43.0 | 17.5 | 8.0 | 39 106 |
| 8+ | 11 693 | 27.4 | 42.7 | 20.3 | 9.5 | 25 061 |
| Дүн | 749 480 | 44.0 | 47.0 | 7.3 | 1.7 | 1253 023 |

Хүснэгт 2. Ажил эрхэлдэг хүнтэй өрх, өрхийн ам бүл, өрхөд ажил эрхэлж байгаа хүнээр

| Өрхийн ам бүл | Ажилгүй иргэнтэй өрх | Үүнээс: Ажилгүй 1 хүнтэй өрх | Ажилгүй 2 хүнтэй өрх | Ажилгүй 3 хүнтэй өрх | Ажилгүй 4 түүнээс дээш хүнтэй өрх | Ажилгүй иргэд |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 3 606 | 100.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 3 606 |
| 2 | 9 924 | 95.2 | 4.8 | 0.0 | 0.0 | 10 400 |
| 3 | 18 298 | 88.6 | 10.7 | 0.7 | 0.0 | 20 504 |
| 4 | 26 450 | 91.2 | 8.1 | 0.6 | 0.1 | 28 977 |
| 5 | 17 825 | 86.1 | 13.2 | 0.7 | 0.0 | 20 419 |
| 6 | 9 411 | 75.0 | 20.7 | 4.3 | 0.0 | 12 176 |
